

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY

Дэлхий рүү тэмүүлж,  
дэвжээгээ засна


Африк бол мандаж буй нар

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл

2013. 03 сар. №06 (040)

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

## ШИНГЭН ЭДИЙН ЗАСАГ





## MICHELIN МОНГОЛД

ВАГНЕР АЗИ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ КОМПАНИ НЬ "MICHELIN" БРЭНДИЙН УУЛ УУРХАЙ, ХҮНД МАШИН МЕХАНИЗМЫН ДУГУЙНЫ АЛБАН ЁСНЫ ДИЛЕРЭЭР 2002 ОНООС ХОЙШ АЖИЛЛАЖ ИРСЭН БӨГӨӨД 2012 ОНЫ 11-Р САРЫН 30-НЫ ӨДӨР "MICHELIN"-КОМПАНИТАЙ "MICHELIN"-БРЭНДИЙН БҮХ ТӨРЛИЙН ДУГУЙ ҮҮН ДОТРОО УУЛ УУРХАЙ ХҮНД МАШИН МЕХАНИЗМ, АЧААНЫ МАШИН БОЛОН АВТОБУСНЫ МӨН СУУДЛЫН ЖИП МАШИНЫ ДУГУЙГ АЛБАН ЁСНЫ ЭРХТЭЙГЭЭР МОНГОЛД БОРЛУУЛАХ ДИЛЕРИЙН ГЭРЭЭГ ЗУРАН АЖИЛЛАЖ БАЙНА.



Баянгол Дүүрэг 4-р хороо  
Баруун үйлдвэр - 133  
Вагнер Азийн Байр, ш/х-26  
Улаанбаатар-16030, Монгол Улс  
Утас: 11-687588  
Веб: [www.wagnerasia.com](http://www.wagnerasia.com)

 **WAGNER**  
ASIA EQUIPMENT LLC

 **CAT**<sup>®</sup>

## Банкны товч танилцуулга

Худалдаа, хөгжлийн банк нь 1990 онд Монгол улсад хоёр шатлалт банкны тогтолцоо үүссэн түүхэн цаг үед анхны арилжааны банк болон мэндэлсэн түүхтэй.

Өнөөдрийн байдлаар ХХБ 45 салбар, тооцооны төв, 159 АМТ, 1899 ПОС терминал, 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр харилцагчиддаа үйлчилж, дотоод болон гадаадын зах зээл дээр Монгол улсын тэргүүлэгч банк гэсэн байр суурийг эзэлсээр байна.





ХХБ Монгол улсын эдийн засгийн хурдацтай өсөлтөд хувь нэмрээ оруулж буй эдийн засгийн гол салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг гадаад, дотоодын томоохон аж ахуйн нэгж, корпорациуд, гадаадын хөрөнгө оруулагчдын бизнесийн найдвартай санхүүгийн хамтрагч нь байж, итгэлийг нь хүлээн ажилладаг юм.

Олон улсын зах зээл дээр Монгол улсын нэр хүндийг өргөгч Худалдаа, хөгжлийн банк:

- Дэлхийн томоохон 150 гаруй банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна;
- Азийн Хөгжлийн Банк болон Олон Улсын Санхүүгийн Корпорациас санхүүжилт авсан;
- 2006 онд арилжааны банкуудаас анх удаа өөрийн үйл ажиллагаандаа олон улсын үнэлгээний Moody's агентлагаар үнэлгээ хийлгэн, банкны үйл ажиллагаа тогтвортой, сайн хэмээн дүгнэлт авсан;
- Монгол улсаас анх удаа олон улсын санхүүгийн зах зээлд 300 сая ам.долларын бондын хөтөлбөрийн хүрээнд 75 сая ам долларын бондыг 2007 онд амжилттай гаргаж чадсан анхны аж ахуйн нэгж болсон;
- 2010 оны 10-р сард 175 сая ам.доллар, 2012 оны 9-р сард 300 сая ам.долларын бондыг олон улсад тус тус арилжаалж, мөн л Монгол улсаас олон улсад анх удаагаа бонд гаргагч байгууллага гэдгээ хэвээр хадгалж байгаа юм.
- 2012 оны 2-р сард дэлхийн тэргүүлэгч банк болох "Goldman Sachs" групптэй гэрээ байгуулан хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн нь ХХБ-ны өсөн нэмэгдэж буй бизнесийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, мөн Монгол улсын эдийн засгийн өсөлтөд томоохон түлхэц болохуйц үйл явдал боллоо.

## Зах зээлд эзлэх хувь

2012.12.31

**Нийт хөрөнгийн харьцаа**

**Нийт зээлийн харьцаа**

**Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа**

**Цэвэр ашгийн харьцаа**


Ногоон хөгжлийн пөлөө

**MONGOLIAN  
ECONOMY**

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Х.Хулан

Б.Үүрийнтуяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /9409-2904/

Д.Баттулга /9902-2279/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш /8870-3633/

**ХАЯГ:**

Улаанбаатар, ЧД IV хороо,  
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

[info@mongolianeconomy.mn](mailto:info@mongolianeconomy.mn)

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

**БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:**

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд

“MONGOLIAN ECONOMY”  
СЭТГҮҮЛИЙН

II УЛИРЛЫН ЗАХИАЛГА  
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)


## Дэлхий рүү тэмүүлж, дэвжээгээ засна



...Монголын гэх тэрхүү брэнд бүтээгдэхүүн нь “байгалийн” гэсэн тодотголоороо дэлхийд тодрох ёстой” хэмээн Ерөнхий сайд “төсөөлсөн” ...9

## Цэнхэр эдийн засаг

...Аливаа амьд оршихуйн үүсэл уснаас эхтэй бол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түлхүүр ч уснаас шууд хамааралтай...16



## Гараа нэгтэй орнууд

...Чөлөөт худалдааны үр дүнд бид томоохон өөрчлөлтүүдтэй зохицох хэрэг гарсан. Бүхэл бүтэн салбар арчигдсан ч өөр нэгэн цоо шинэ салбар хүч түрэн гарч ирсэн юм. Бидний устана хэмээн хүлээж байсан салбар харин ч илүү хүчирхэгжсэн...28

## Тарган дэлхий

...Таргалалт дэлхий дахинаа цэцэглэж байгаа энэ үед “The Economist” сэтгүүлийн эрүүл мэндийн салбарын сэтгүүлч Шарлот Ховард өөх хэмээх амьгүй булчинтай хэрхэн тэмцэх талаар бичсэн зөвлөгөөг хүргэж байна...43



## ЭДИЙН ЗАСАГ

- 9 Усны өдөрт
- 8 Дэлхий рүү тэмүүлж, дэвжээгээ засна
- 12 Брэнд хэрхэн бий болгох вэ
- 16 Цэнхэр эдийн засаг
- 18 Хөрвөсөн ус хөгжлийн түлхүүр
- 21 Хандлага
- 23 Ус юу бүтээдэг вэ
- 24 Ухаалаг хэмнэлт
- 28 Гараа нэгтэй орнууд
- 31 Улам хүчирхэгжинэ
- 32 Угогүй Орос
- 33 Үйлчилгээний салбарт хөгжлийн зохистой бодлого үгүйлэгдэж байна
- 35 Эдийн засагт төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үзүүлэх нөлөө

## ЕРТӨНЦ

- 38 Африк бол мандаж буй нар
- 42 Тарган дэлхий

## МОНГОЛ

### Өрсөлдөх чадвар

**Эдийн засгийн бодлого**, өрсөлдөх чадварын судалгааны төв (ЭЗБӨЧСТ)-өөс Монголд анх удаа орон нутгийн өрсөлдөх чадварыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар судалж, тайлан гаргалаа. Энэхүү тайлан нь аймаг бүрийн нийгэм, эдийн засгийн голлох үзүүлэлтүүдээс гадна бизнес эрхлэгчдийн үнэлэлт, хүлээлтийг харуулжээ. Өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Орхон аймаг тэргүүлж, Өмнөговь, Дархан-Уул аймаг удаалсан байна.

### Уул уурхай

Монгол Улс 2012 онд 31.1 сая тонн нүүрс




олборлож, үүнээс 20.5 сая тонныг нь экспортолсон бөгөөд улсын төсөвт 828.5 тэрбум төгрөгийн орлого оруулжээ. Өнөөдрийн байдлаар 60 орчим аж ахуйн нэгж нүүрс олборлож байгаагийн 20 гаруй нь

нүүрсээ түүхийгээр болон баяжуулж экспортод гаргаж байна.

### Эрчим хүч

Улаанбаатар хотын дулаан хангамж 2013-2014



оны өвөл нийт хэрэглээг даах хүчин чадалгүй болсныг албаныхан мэдээлэв. Иймд ирэх өвлийн оргил ачааллаас өмнө нийслэлийн дулаан хангамжийн найдвартай ажиллагааг хангахын тулд Баянзүрх дүүргийн VIII хорооны нутаг дэвсгэрт орших "УС-15" халаалтын зуухыг шинэчлэн 300 МВт хүчин чадалтай дулааны станц барихаар боллоо.

### Чингис бонд

"Чингис" бондын хөрөнгөөр дараах дөрвөн төслийг санхүүжүүлэх зөвлөмж гаргажээ. Үүнд, 2016 онд багтаан бүх аймгийн төвийг хатуу


хучилттай авто замаар нийслэлтэй холбох, нийслэлийн дахин төлөвлөлт буюу түгжрэл үүсгэдэг 33 замын Т хэлбэрийн уулзварыг дөрвөн замын уулзвар болгох, босоо, хэвтээ тэнхлэгийн хурдны хоёр зам байгуулах, Оюутолгойн уурхайд эрчим хүч нийлүүлэх боломжтой 300 мВт-ын хүчин чадалтай цахилгаан станцыг Тавантолгойн уурхайд түшиглэн барих, 1800 км төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлж, Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэлх 270 орчим км төмөр



замын суурь бүтцийг санхүүжүүлэх зэрэг багтаж байгаа аж.


### Нийслэл

### Нийслэлийн гэр




хорооллын дахин төлөвлөлтийг гурван бүсэд хувааж, эхний ээлжинд нэг, хоёрдугаар бүсийн 12 байршилд дахин төлөвлөлт хийхээр НИТХ-аар баталлаа. Нэгдүгээр бүсэд инженерийн шугам сүлжээтэй ойр, дэд бүтцийн асуудлыг хялбар шийдэх боломжтой "Дэнжийн мянга", долдугаар хороолол зэрэг таван байршлын газар хамрагдаж байгаа бол хоёрдугаар бүсэд инженерийн шугамаас алслагдсан, дэд бүтцийн асуудлыг шинээр

Монголын нүүрсний экспорт (сая тонн)



Эх сурвалж: УСГ, МУ-ын Гаалийн ерөнхий газар

Хятадын коксжих нүүрсний импортын бүтэц (%)



■ Монголын экспортын эзлэх хувь ■ Бусад

Эх сурвалж: Tex Report, China Coal Resource

шийдвэрлэх Хайлааст, Ханын материал, Баянхошуу зэрэг долоон байршлын газар хамрагдана.

**Хүнд үйлдвэр**

ҮХААЯ-наас зэс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг ашигт малтмалыг дотооддоо боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх бодлого баримтлах болсноо мэдэгдлээ. Ирэх дөрвөн жилд Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор, Дархан-Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордуудад түшиглэн орчин үеийн техник, технологи бүхий төмөрлөгийн цогцолбор байгуулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргахыг эрчимжүүлэх, нүүрсний химийн үйлдвэрийг хөгжүүлэхэд анхаарах юм байна. Ингэснээр 2021 он гэхэд ДНБ-ийг 41 тэрбум ам.долларт хүргэх боломжтой гэж үзжээ.

тусламж авсныхаа дараа эмчилгээний төлбөрөө төлөх боломж олгох шинэ системийг энэ онд багтаан нэвтрүүлэхээр болжээ. Мөн өвчтөн эмчилгээгээ хийлгээд, төлбөрөө төлснийхөө дараа эрүүл мэндийн даатгалын нөхөн олговорт хамрагдах бөгөөд ингэснээр нийт төлбөрөөс 70 хүртэл хувийн хөнгөлөлт эдлэх аж.

**Япон**



**Японы** эдийн засаг 2012 оны уналттай байдлаасаа тооцоолж байснаас хурдан сэргэж буйг тус улсын Засгийн газраас гаргасан ДНБ-ий мэдээ харуулж байна. Японы ДНБ дөрөвдүгээр улиралд 0.2 хувиар өссөн бөгөөд өнгөрсөн улиралд 0.4 хувийн агшилттай байсан билээ.

**Энэтхэг**

**Дэлхийн** банкны Ерөнхийлөгч Жим Ёонг Ким Энэтхэг айлчлахдаа “Энэтхэгийн эдийн засаг ирэх оноос зургаан хувийн өсөлттэй байх бөгөөд цаашид ч өснө” гэжээ. Дэлхийн банкнаас гаргасан эдийн засгийн судалгаагаар 2013-2014 онд тус улсын эдийн засаг 6.1-6.5 хувийн өсөлттэй байна гэх тооцоо гаргасан байна.



**Энэтхэгт** өнгөрсөн сард машины худалдаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувиар буурсан нь сүүлийн 12 жилийн хугацаанд тохиогоогүй явдал боллоо. Энэтхэгийн Автомашин үйлдвэрлэгчдийн холбооноос “Өнгөрсөн сард 158.513 ширхэг машин худалдаалсан бөгөөд ийнхүү автомашины борлуулалт эрс буурсан нь шатахууны үнэ, зээлийн хүү нэмэгдсэнтэй холбоотой” гэв. ■

**А.АМАРСАЙХАНЫ БУЛАН**

**ДЭЛХИЙ ДАХИНД**

**Хятад**



Хятадын Эрүүл мэндийн яамнаас өвчтөн эмнэлгийн

Бүгдээрээ адилхан төлбөрөө төлөөд байгалийн баялаг ашигладаг. Гэвч...

**Ноолуур:** 100% Дамбынх

**Алт:** 34% Улсынх, 66% Болдынх

**Тоосго:** 100% Доржийнх

**Хайрга:** 100% Гомбынх

**Мод:** 100% Батынх

**Элс:** 100% Сүхийнх

Шог зургийг А.Амарсайхан

ОНЦЛОХ

# УСНЫ ӨДӨРТ

Б.ЭНХМАРТ

“Mongolian Economy” сэтгүүл энэ дугаартаа усыг онцолж байна. Аз жаргал, баяр хөөр, уй гуниг, гачигдал гээд сайн, муугаар дүүрэн хорвоогийн ширхэг эс бүрийг тэжээгч ус хэмээх рашааны нөөц, эрүүл ахуйд дэлхий нийт SOS зарлаад цөөнгүй жил өнгөрлөө. АНУ тэргүүтэй улс, орнуудын эрдэмтэн, судлаачдын гаргасан толгой эргэм тоон мэдээллүүдийг нүд, чихнийхээ хажуугаар өнгөрөөхийг хүсэвч, өдөрт 6000 хүүхэд зөвхөн усны эрүүл ахуй хийгээд хомсдолоос болж амиа алдаж байгааг харах харамсалтай байна. Ялангуяа бага насны хүүхдүүд хумхаа, суулга зэрэг өвчинд маш амархан нэрвэгдэж байгааг дэлхий онцолж байна. Тиймээс бид усыг хэрхэн зөв ашиглах, нөөцлөх талаар хөндлөө.

Ус уудаг, угаадаг, асгадаг үнэгүй эд байхаа болиод уджээ. Дэлхий нийт усыг саарал, цэнхэр, хөрвөсөн хэмээн олон ангилж, дахин бас дахин ашиглаж байна. Та манай сэтгүүлчийн усны тухай бичсэн нийтлэлээс усыг дахин ашиглахын ач тус хийгээд усны эдийн засгийн талаар уншаарай. Түүнчлэн усан цэнхэр гариг дээр амьдарч буй 783 сая хүн ундны усны хомсдолтой, 2.5 тэрбум хүн ариун цэврийн шаардлага хангасан үйлчилгээ авч чадахгүй байна. Энэ тоо өсөн нэмэгдэж, 2025 он гэхэд нийт хүн

амын 60 хувьд хүрнэ гэх таамаг ч гарчээ. Үүнээс сэргийлэх, ядаж 45 хувь нь “цангахын” тулд сайн менежмент хэрэгтэй тухай “Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх нь” төслийн зөвлөх багийн зохицуулагч Ян Броны сонирхолтой ярилцлагыг энэ дугаараас сонирхож болно.

Мөн манай энэ дугаараас “Монголын эдийн засгийн чуулган-2013”-ын монгол брэнд хэрхэн бий болгох тухай хэлэлцүүлгийн үеэр гарсан санал, санаачилгуудыг, Канад улсаас Монголд суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Грегори Голдхауктай хийсэн сонирхолтой ярилцлага зэргийг тухлан сонирхоорой. Түүнчлэн уншигч та бүхэнд “The Economist” сэтгүүлд нийтлэгдсэн чухал нийтлэлүүдийг орчуулан хүргэж байхаар болсноо дуулгахад таатай байна. Тухайлбал, энэ удаагийн дугаарт тус сэтгүүлийн тусгай дугаарт нийтлэгдсэн “Африк бол мандаж буй нар”, “Тарган дэлхий” гарчигтай нийтлэлийг орчуулан хүргэлээ. Үүнээс гадна Монголын төр, хувийн хэвшил, иргэн, олон улсын донор байгуулагуудын төлөөлөл бүхий нийт 1000 гаруй хүн оролцсон “Эдийн засгийн чуулган-2013”-ын үеэр Голландын Ерөнхий сайд асан Вим Кокос Голланд өвчнийг хэрхэн гайхамшиг болгож чадсан тухай ярилцлагыг манай сэтгүүлч тусгайлан авсныг бид дараагийн дугаараараа танд хүргэх болно. ■



ТОЙМ

# ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЖ, ДЭВЖЭЭГЭЭ ЗАСНА

И.ОТГОНЖАРГАЛ

*...Брэндийг бий болгохын тулд хувийн хэвшил, төр, засаг, иргэний нийгмийн оролцоо ямар байх, хэн нь юу хийж чадах вэ гэдэг дээр талуудын байр суурь илүү тодорхой гарч байсан нь энэ удаагийн чуулганы онцлог байсан гэж үзэж болно...*

Арьс шир, ноос, ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, оёдол загвар, аялал жуулчлал. Эдгээрийг уул уурхай гэсэн ганцхан өнгө давамгайлсан Монголын эдийн засгийг солонгоруулах салбараар тодруулаад байна. Энэ сарын 4-5-нд болсон “Монголын эдийн засгийн чуулган 2013”-ын үндсэн сэдэв нь Монголын брэндийг хэрхэн бий болгох вэ гэдэг байв. Чуулганд оролцогчдын ирц, идэвх өмнөх жилүүдийнхээс сайн байлаа.

Нийт экспортын 80 гаруй хувийг зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийхээ 30-хан хувийг боловсруулдаг Монгол Улсын хувьд эдийн засгаа төрөлжүүлэх нь ойрын зорилго байх учиртай. Шинэчлэлийн Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг ч уул уурхайн орлогоороо бусад салбараа хөгжүүлж, эдийн засгаа солонгоруулна гэдгийг дээрх чуулганы нээлтийн үгэндээ онцлов. Мөн тэрбээр “Монгол үндэсний биш, бүс нутгийн биш, дэлхийн түвшний брэндтэй болох тэмүүлэлтэй байгаагаа илэрхийлсэн. Монголын гэх тэрхүү брэнд бүтээгдэхүүн нь “байгалийн” гэсэн тодотголоороо дэлхийд тодрох ёстой” хэмээн

Ерөнхий сайд “төсөөлсөн”. Эдийн засгийн эрчимтэй өсөлттэй орнуудын тоонд орж, дэлхийд нэр нь цуурайтаад буй Монголыг өнөөдөр ертөнцийн хүмүүс юугаар нь таньж байна вэ гэдгийг бодоод үзье. “Уул уурхай хөгжиж байгаа орон”, “Чингисийн нутаг” гэдгээрээ л танигдаж байгаа. Өөрөөр хэлбэл, энэ хоёр өгүүлбэр одоогоор дэлхийд талын Монголыг сурталчилж байгаа “брэнд” гэж үзэж болох юм. Бид өнөөдөр баялаг өв соёл, оюуны чадавхи өндөртэй монгол хүнээрээ, экологийн цэвэр хүсний бүтээгдэхүүн, үйлдвэрлэлээрээ дэлхийн брэндийн зах зээлд хөл тавьж, танигдахыг хүсч байна. Тийм хүсэл тэмүүлэл, хүлээлт Монголын төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн, олон улсын байгууллагынхан, эрдэмтэн судлаачдын сэтгэл зүрхэнд гүн бат бий болсон нь энэ удаагийн Монголын эдийн засгийн чуулганаас тод харагдав. Тэгвэл дэлхийн брэндийн зах зээл Монголоос хэр хол байна вэ, бидэнд шууд брэнд болгоод гаргаж ирэх олон улсын стандарт, шаардлагыг хангасан бараа, бүтээгдэхүүн байна уу. Эхлээд үндэсний, бүснугийн, тэгээд дэлхийн брэнд бий болгох ёстой юу. Брэнд бий болгох асуудал нь цаг хугацаа, хөгжлийн асуудал. 40- 50 жилийн

дараа бид бусдынх шиг брэнд гаргаж болно. Үгүй ээ, зөв явбал 2-3 жилийн дотор брэнд бий болгох боломж Монголд байна. Энэ мэт эсрэг тэсрэг байр суурь, олон асуудлын хамт ар араасаа хөвөрч байлаа. Брэнд гэдэг нь дэлхийн энтэй асуудал учраас олон талын байр суурь, хурц маргаан, шүүмж өмнөхөөс их хөвөрсөн ч байж болох. Дотоод, гадаадын 1000 гаруй төлөөлөгч байсны дотор АХБ-ны дэд ерөнхийлөгч хатагтай Лакшми Венкачаталам, Голландын Ерөнхий сайд асан Вим Коок зэрэг хүндтэй зочид ч байв.

## “Хийе, бүтээе, дэмж, бид чадна”

Брэндийг бий болгохын тулд хувийн хэвшил, төр, засаг, иргэний нийгмийн оролцоо ямар байх, хэн нь юу хийж чадах вэ гэдэг дээр талуудын байр суурь илүү тодорхой гарч байсан нь энэ удаагийн чуулганы онцлог байсан гэж үзэж болно. Ялангуяа дээрх зургаан салбарын үйлдвэрлэгчдийн хувьд техник технологи, ажиллах хүч, үйлдвэрлэл нь байна. Гагцхүү үйлдвэрлэлээ өргөжүүлэх, бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах, дэвшилт технологи нэвтрүүлэх, экспортоо нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг нь үндсэндээ дараах гурван чиглэлд багцалж болох аж. Үүнд нэгдүгээрт, эргэлтийн хөрөнгийн асуудал. “Бид хийе, бүтээе. Хүсч буй брэндийг бий болгож чадна.”

Тийм боломж байна” гэдэг дэврүүн үгс хурлын үеэр асуулт асууж, санал сэтгэгдлээ хэлсэн хувийн хэвшлийн төлөөлөл бүрээс гарч байсан. Тухайлбал, нэгэн бизнесмэн “Брэнд бий болгох гэж байгаа салбарт мэдээллийн технологийг яагаад орхигдуулсан юм бол. Би долоо дахь нь мэдээллийн технологийн салбар байж чадна гэдэгт итгэлтэй байна. Тухайлбал, манай компани Монголд зөврийн компьютер үйлдвэрлээд, экспортолж байгаа. Ухаалаг гар утас хийх боломжтой. Бидний үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн олон улсын чанар, стандартын шаардлага хангасан. Тийм ч учраас гаднаас захиалга ирж байна. Андроид утас, смартфонг Монголоос хамгийн хямд үнээр авч болно. Төрийн дэмжлэг л хэрэгтэй байна. Төрийн түшээд та бүхэн гаднын iPad, нөүтбүүк хэрэглэхийн оронд үнэхээр л брэнд бий болгох гэж байгаа бол дотоодынхоо бүтээгдэхүүнийг хэрэглэж, үндэсний үйлдвэрлэлээ дэмжих хэрэгтэй байна” хэмээв. Түүний саналыг оролцогчид алга ташиж дэмжсэн. Брэнд бий болгох санаачилга гаргаж байгаа төр, засгийнхнаасаа эхлээд дотоодынхоо бараа бүтээгдэхүүнийг хэрэглээн-дээ нэвтрүүлээчээ гэдэг санал үүгээр зогсоогүй. Учир нь, манай хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд чанар сайтай байдаг учраас үйлдвэрлээд гаргаж байгаа бараа, бүтээгдэхүүн нь ч нүүр улайхааргүй байдаг гэдгийг тэд итгэл төгс хэлж байсан юм. Тиймээс илүү сайныг бүтээх, олон хүнийг ажлын байртай болгох боломж бий тул хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг урт хугацаатай/доод тал нь найман жил/, бага хүүтэй хөгжлийн зээлээр дэмжих нь чухал гэдэгтэй олон хүн санал нэгдэж байсан.

## Ноос, ноолуурынхнаас суралц



Дараагийн асуудал нь татварын бодлогоор үйлдвэрлэлийг дэмжих юм. Дотоодод үйлдвэрлэх боломжтой импортын барааны гаалийн татварыг нэн даруй нэмэгдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлээд, экспортолж байгаа тохиолдолд татварын хөнгөлөлт чөлөөлөлт, нөхөн олговор олгох нь чухал байна гэдэг хүсэлтийг олон оролцогч хэлж байлаа. Монголд зээл богино хугацаатай, өндөр хүүтэй олддог учраас үйлдвэрлэл явуулахад тун бэрхшээлтэйг жил бүрийн эдийн засгийн чуулганаар ярьж ирсэн ч энэ удаа брэнд бий болгож, үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилт, зорилго төр, засагт байгаа бол үүнийг хийхээс аргагүйг хувийн хэвшлийнхэн дахин сануулсан. Монголчууд өдгөө хувцас хэрэглэл, хоол, хүнснийхээ дийлэнх хувийг импортоор хангаж байгаа. Гэтэл дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж нөхцөл бий. Тухайлбал, “Буян” компанийн захирал Б.Жаргалсайхан “Бид загвар, чанар сайтай, нэмүү

өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь чухал байна. Ноос, ноолуурыг түүхийгээр нь урд хөрш рүү гаргахаа зогсоё. Дотоодод түүхий эдээ бүрэн боловсруулах үйлдвэрлэл, технологи, хүн хүч байна. Жилд энэ салбарыг 350 сая ам.долларын эргэлтийн хөрөнгөөр дэмжээд байх юм бол нэг тэрбум орчим ам.долларын ашиг, орлоготой, 40.000 хүнийг сарын нэг сая төгрөгийн цалинтай ажлын байраар хангах боломжтой. Энэ асуудлыг л манай холбоо тавьж байна” хэмээсэн. Монголын ноос, ноолуурын холбоо чуулганд нэгдсэн зохион байгуулалт сайтай оролцож байсан. Тэд ноолуурын үйлдвэрлэлийг хэрхэн дэмжиж, ямар үр дүн хүлээж болох талаар төсөл бичиж, Засгийн газрын холбогдох хүмүүст өгсөн аж. Тэдний энэ нэгдмэл байр суурь нь бусад салбарын холбоодод санаа авч, үлгэр дууриалал үзүүлэхээр байсан. Иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшлийнхэн асуудлыг зөвхөн өөртөө хамааруулж ярих биш, нэгдмэл”



ФОТОГ Э.ЗОРИГТ

байр суурьтай, хийх, хэрэгжүүлэх ажлаа салбарынхаа хэмжээнд авч үзвэл үр дүн гаргах, төрийн дэмжлэг авахад ч дөхөмтэй нь чуулганы үеэр мэдрэгдэж байсан билээ. Тухайлбал, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг “Нэгэнт мөнгө зарж байгаа юм чинь аль нэг компанийг дэмжих биш, салбараар нь босгож, нэгдсэн том корпораци руу аваачих ёстой. Нөгөө талаас түүхий эд бэлтгэдэг монгол иргэнээ, малчнаа дэмжих хэрэгтэй. Өнөөдөр хятад наймаачны гар хөл болсон түүхий эдийн ченжүүд рүү бараагаа бариад гүйж байна. Ченж рүү чиглэсэн түүхий эдийн урсгалыг үндэсний үйлдвэрлэл рүү татах схемээ бид хийх ёстой. Засгийн газар одоо хөдөөгийн бизнес, хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байна. Араас нь экспортоо дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэв. Мөн тэрбээр “Гаднын хэн нэгэнтэй өрсөлдөх тухай ярихаасаа өмнө импортыг орлох бараа, бүтээгдэхүүнээ өөрсдөө хийдэг болох

хэрэгтэй байна” гэсэн нь хувийн хэвшлийнхний зорилготой нэгэн үзүүртэй юм. Түүнчлэн Сайханбилэг монгол брэнд бий болгоход зөв бодлогоор явбал 20-30 жил биш, 2-3 жил орно гэсэн өөдрөг тэмүүлэлтэй байна. Ийнхүү брэнд бий болгохыг зөвхөн хувийн хэвшлийнхэн хүсээд, зориод байгаа юм биш, төр, засгийн удирдах хүмүүс том зорилт тавин, ихээхэн өрнүүн хүсэл тэмүүлэлтэй байгаа нь олзуурхуштай.

Төрийн дэмжлэг байх ёстой гурав дахь гол зүйл нь гадаад зах зээлд Монголын имижийг бүрдүүлэх, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний маркетинг, сурталчилгаа хийх. Дотооддоо болон экспортод гардаг чанартай бараа, бүтээгдэхүүн байлаа гээд гадагшаа сурталчилгаа хийхгүйгээр брэнд бий болгоно гэж байхгүй. Үүнийг олон улсын брэндийн зөвлөх мэргэжилтнүүд сонирхлыг өдөөх гэж ярьдаг юм билээ. Тухайлбал, манай эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайтай өрсөлдөхүйц салбар бол аялал жуулчлал гэж ярьдаг. Тус салбар жилдээ нэг сая жуулчин хүлээн авна гэдэг том зорилт хэдэн жилийн өмнөөс дэвшүүлсэн. Тэгсэн хэрнээ өнөөдрийг хүртэл энэ салбарын сурталчилгаанд хөрөнгө огт зарцуулж байгаагүй гэж хэлж болно. Эдийн засгийн чуулганы “Аялал жуулчлал монгол брэнд болох нь” салбар хуралдааны үеэр нүүдлийн соёл иргэншил, үлэг гүрвэл, Чингис хаанаа брэнд болгох асуудлыг дэвшүүллээ. Түүнчлэн энэ жилээс 300 сая төгрөгөөр “National Geographic”-ийн “Traveler” сэтгүүлээр эх орноо сурталчилах таатай мэдээг сонсголоо. Маркетинг муутай явж ирсэн энэ салбарын зовлонг төр ойлгож, дэмжих аваас брэндийн ирээдүй ойрхон.

## Ерөнхийлөгчийн магтаал ба ташуур

Хоёр өдрийн хуралдаанаар брэндтэй холбоотой мэргэжилтэй боловсон хүчин, сэтгэлгүй ажилтан, монгол хүний үнэлэмжийн асуудал ч урьдын адил яригдсан. Гэхдээ хамгийн гол зүйл нь брэндэд ойрхон ирээдүйтэй салбаруудын үйлдвэрлэгчид зовлон тоочиж, олон зүйл хүсэхгүй байна. Тэдний хэлж ярьж, төрөөс дэмжлэг авах хүсэлтээ тодорхой дэвшүүлж буйгаас үзэхэд галт тэрэг хэдийнэ хөдөлжээ. Гагцхүү хэр уран жолоодлого үзүүлэхээс брэнд бий болгох салбаруудын хувь заяа шийдэгдэх нь. Чуулганд оролцож, ухаан бодлоо уралдуулсан төр, засгийн төлөөллүүд ч хувийн хэвшил, иргэний нийгмийн хийж бүтээх хүсэл тэмүүлэлтэй, тодорхой зорилготой хүмүүсээ дэмжинэ гэдгээ илэрхийллээ. Нэг үгээр, брэнд бий болгохтой холбоотой хоёр өдөр хэлэлцээд өнгөрөх биш, дэлхий рүү тэмүүлж, дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын дэвжээгээ засна гэсэн үг. Шадар сайд Д.Тэрбишдагвын “Бид дэлхийн хэмжээний стандарттай байж л брэнд бүтээгдэхүүнтэй болно” гэж хэлснийг эс тооцвол брэнд бий болгоход чухлаар тавигдах чанар, стандартын асуудал тийм ч нухацтай яригдсангүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ч хоёр дахь өдрийн хурлыг нээх үеэрээ эдийн засгийн чуулганы үр дүн харагдахгүй байгаа учраас брэнд бий болгоход зориулж үг бэлдээгүй гэдгээ хэлсэн. Тэрбээр уг чуулган зохион байгуулалт, хэлбэрийн хувьд сайн болж байгаа. Харин үр дүн, гүйцэтгэл байхгүй байгааг хатуухан шүүмжилж, зохион байгуулагчдыг “ташуурдсан”. Тиймээс “Монголын эдийн засгийн чуулган 2013” үр дүн гаргаж, үндэсний үйлдвэрлэл хөгжин, эдийн засаг солонгорч, ажилтай, орлоготой монгол хүн олширч, хөнгөн үйлдвэрлэлийн салбар хөлд орж, брэнд бий болно гэж найдъя. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

# БРЭНД ХЭРХЭН БИЙ БОЛГОХ ВЭ

Б.ҮҮРИЙНТУЯА

...“Монголын эдийн засгийн чуулган 2013”-д оролцогч төр, хувийн хэвшил болон бусад салбарын төлөөллүүдийн брэнд бий болгох тухай санаа бодлыг хүргэж байна...



Корали Геверс



Рандольф Коппа

## Б.Жаргалсайхан /“Буян” компанийн захирал/:

Брэнд бий болгохын тулд эхлээд түүнийг сайн ойлгох нь чухал. Брэнд гэдэг нь тухайн улсын түүх, соёл, зан заншил гэсэн үг. Тухайлбал, “Louis Vuitton” брэндийн нэг ноолууран цамцны дундаж үнэ 1000 ам.доллар. Гэтэл цамцны цэвэр өртөг нь ердөө 100 ам.доллар байх жишээтэй. Тэгэхээр үлдсэн 900 ам.долларт нь тухайн улсын соёл, түүх, хөгжлийн үнэ цэнэ шингэж байгаа юм. Үүнийг л брэнд гэдэг. Монголчуудын хувьд брэнд гэж ярих арай эрт байна. Харин Монгол ноолуураар хийсэн “Made in Mongolia” шошготой чанар,

загвар сайтай хувцсыг дэлхийн брэндүүдээр дамжуулан экспортод гаргах боломж бий. Улсынхаа онцлог, нөөц бололцоогоо ашиглан бид дэлхийн хэмжээний бүтээгдэхүүнийг гаргаж болно. Ингэхийн тулд бидэнд цаг хугацаа, хангалттай хөрөнгө санхүүжилт хэрэгтэй байгаа юм. Өнөөдөр Монгол Улсыг хөгжилтэй орон гэж тодорхойлохгүй. Үндэсний брэнд бүтээхийн тулд хоёроос доошгүй үе дамжиж байж энэ бүхэн биелэлээ олно. Ноос, ноолуурын салбарыг хөгжүүлж, улмаар брэнд бүтээгдэхүүн гаргахын тулд эхний ээлжинд энэ салбарт 350 сая ам.доллар шаардлагатай. Бид түүхийг эд нийлүүлэгч бус нэмүү өртөг

шингэсэн бүтээгдэхүүн экспортлогч орон болох хэрэгтэй. Бидэнд чадамжаас гадна дадлага, туршлага хангалттай байна.

## Корали Геверс /Дэлхийн банкны суурин төлөөлөгч/:

Монголын эдийн засгийн форум цар хүрээгээ тэлсээр байна. Энэ нь сайны дохио. Уг чуулганд оролцож буй төлөөллүүд тодорхой үр дүн, шийд хүлээж буй нь илт. Гэвч Монголын эдийн засгийн чуулганы үндсэн зорилго нь шийдэлд хүрэх арга замыг хувийн хэвшил болон бусад салбарын төлөөллүүдтэй хэлэлцэх, ярилцахад орших болов уу. Энэ жилийн сэдвийн хувьд ач холбогдол өндөртэй. Учир нь, монголчууд үндэсний брэндээ хэрхэн бий болгож, улмаар дэлхийд таниулах талаар хэлэлцэж байна. Гэхдээ ямар бүтээгдэхүүнийг брэнд болгох вэ гэхээс илүүтэй яаж бий болгох талаар ярилцах нь чухал. Үүнд хүсэл болоод зүтгэл хэрэгтэй. Ингэснээр стандарт бүрдэж, түүнийг дагах болно. Монгол Улсыг төлөөлөх брэнд нь өөрөө хамтын ажиллагааны үр дүнд бий болно. Монголд брэнд болохуйц олон зүйл бий. Гагцхүү бэрхийг туулах хатуужил, тууштай зан хэрэгтэй.

## О.Амарцэнгэл /Монголын сүүний нэгдсэн холбооны тэргүүн/:

Монгол брэнд бий болгож, дэлхийд таниулахыг зорьж байгаа нь алсыг харсан, чухал ач холбогдолтой зүйл юм. Форумгаас гарах шийдлүүдийг биелүүлж чадвал энэ нь том амжилт болох учиртай. ▶



М.БОЛД



Б.ИНДРАА



Б.ЖАРГАЛСАЙХАН

Энэхүү хамтын ажиллагаа үр дүн авчирна. Үндэсний брэндтэй болох нь монголчууд бүтээгч ард түмэн болох цаг болжээ гэх уриалга юм. Дэлхийн хэмжээний брэндийг өнөөдөр, маргаашийн дотор бүтээж чадахгүй ч, эхлээд үйлдвэрлэгч орон болохыг зорих хэрэгтэй. Ингэхийн тулд санхүүгийн хямд эх үүсвэр шаардлагатай. Монголын бизнес эрхлэгчдэд хөрөнгийн хуримтлал гэж үндсэндээ байдаггүй. Иймд зээл, хөрөнгийн бирж зэрэг хөндлөнгийн санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй болж байгаа юм. Тухайлбал, Чингис бондын хөрөнгө тэр эх үүсвэрийг бүрдүүлж өгч болох. Нөгөөтэйгүүр Засгийн газар уг санхүүжилтийг зөв хуваарилж, бүтээн байгуулалт тал дээр анхаарч олгоосой гэж хүсэж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг брэнд болгоно гэж байгаа. Гэтэл энэ салбарт бодит дэмжлэгээс гадна логистикийн асуудал хүнд байна. Мөн кластерийг хөгжүүлж брэнд болохуйц салбаруудаа дэмжих нь хамгийн үр дүнтэй арга байх болов уу.

**Б.Индраа /“Үндэсний аялал жуулчлалын байгууллага” ТББ-ын Удирдах зөвлөлийн дарга/:**

Аялал жуулчлал бол эрсдэлтэй салбар. Онолоор бол энэ салбар нь 16 дэд салбараас бүрддэг. Гадаадын зах зээл өнөөгийн Монголын аялал жуулчлалын салбарыг тодорхойлж буй нь харамсалтай. Эрсдэлийг өнөөдөр, маргаашаар дүгнэхэд

хэцүү. Зорилтот зах зээл дээрх эдийн засгийн уналт, үнийн уналт зэрэг бодит эрсдэлийг нягт тооцох, судалгаа хийх хэрэгтэй. Брэндийн хувьд Монголд уламжлал, өв соёлын нөөц асар их. Эдгээрээ сурталчлахын өмнө бид Монгол Улсаа сурталчилах нь зүйтэй. Гэвч аялал жуулчлалын өнцөгөөс харахад, Монгол дэлхийд уул уурхайн орон гэдгээрээ танигдаж байна. Гэтэл манай улс нүүдлийн соёл иргэншил нь амьд байгаа гуравхан орны нэг. Түүхийн баялаг соёл, палеонтологи, археологийн асар их нөөцөө гадаадын зах зээлд таниулах шаардлагатай юм. Ингэхийн тулд төр, хувийн хэвшил, орон нутгийн төлөөллүүд хамтраад нэгдсэн брэнд имижийг гаргах хэрэгтэй. Тэрхүү имижийг бүрдүүлэхийн тулд нөөц баялгаа мэдэх, гадаад зах зээлийн хэрэгцээнд суурилан, түүнтэй уялдсан мессежийг өгч, сурталчилах замаар энэ салбарыг хөгжүүлэх учиртай. Монгол гэдэг нэг брэнд гаргах үүний дараагаар бусад үлэг гүрвэл гэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар дэд брэндийг бий болгож болох юм. Брэнд имиж, уриа үгийг хэт яаран шийдэж болохгүй. Судалгааны үндсэн дээр эцсийн мессежээ гаргаж, тууштай хөгжүүлэх хэрэгтэй.

**М.Болд /“Тэнгэр санхүүгийн нэгдэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал/:**

Хөгжлийн санхүүжилт гэдэг нь урт хугацааны бага хүүтэй зээл,

санхүүжилт дээр тогтдог. Өнөөдөр Монгол Улсад ийм тогтолцоо алга. Банкны салбарт 11 их наяд төгрөг эргэлдэж байгаа ч энэ нь нэг жилийн хугацаатай санхүүжилт байгаа юм. Өөрөөр хэлбэл, иргэд нэг жилийн хугацаатай хадгаламж эзэмшдэг. Ийм богино хугацааны хадгаламжаар урт хугацааны төслийг санхүүжүүлэх боломж хомс. Үүнд төрийн болоод мөнгөний бодлого, эдийн засгийн савлагаатай байдал, ханшийн хэлбэлзэл гээд олон асуудал нөлөөлдөг. Харин тэтгэврийн сангийн мөнгийг урт хугацааны зээлийн санхүүжилт болгон ашиглах боломж байдаг. Гэтэл Монгол Улсад ийм төрлийн хөрөнгө асар бага төвлөрсөн байдаг. Тухайлбал, өнгөрсөн жилүүдэд 5-6 их наяд төгрөгийг тус санд хуримтлуулах байсан ч төсвийн урсгал зардалд шингээд алга болсон. Үүнийг нөхөж бүрдүүлж, улмаар арилжааны банкуудаар дамжуулан урт хугацааны төслийн санхүүжилтийг хийхийн хажуугаар гадаад зах зээлээс санхүүжилт олох боломж бий. Жишээ нь, бонд гаргах, гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцаа борлуулах замаар хөрөнгийн эх үүсвэр татаж болно. Ерөнхийдөө үндсэн эх үүсвэр гадаадын зах зээлээс улбаатай байх ёстой. Үндэсний брэндийг бий болгоход дотоодод буй түүхий эдээ ашиглан олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн экспортлох эхлэл болно. Монгол Улсын мал аж ахуйн бүтээгдэхүүн нь байгалийн цэвэр гэдэг утгаараа онцгойрох бүрэн»



Б.ТӨМӨРЧУЛУУ



Б.ГАН-ОЧИР

► боломжтой.

#### **Рандольф Коппа /“Худалдаа хөгжлийн банк”-ны захирал/:**

Монголын хөх тэнгэр, онгон байгаль, хээр тал зэргийг брэнд гэж болно. Үүгээр ч зогсохгүй байгалийн цэвэр, органик сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүнийг уламжлалт аргаар бэлтгэдэг нь эрүүл мэндэд тустай. Эдгээр давуу талаа ашиглан Монголын уудам нутаг, байгаль, өвөрмөц онцлогийг сурталчилан, дэлхийн брэнд болгох хэрэгтэй. Олон улсын зах зээлд байр сууриа эзлэхийн тулд монголчууд зах зээлийн эрэлт хаана байгааг сайтар судлах шаардлагатай. Дэлхийн хүмүүс юу хүсч буйг тодорхойлж, тэдний хүсэлд нийцэх стандарт бий болгох нь зүйтэй. Энэ бүхнийг бүтээхийн тулд логистикийн оновчтой шийдэл чухал. Брэндийг нутагшуулахад хугацаа хэрэгтэй. Олон улсын тавцанд гарах брэнд бүтээгдэхүүнд стандартаас гадна маркетинг, сурталчилгаа амин үүрэгтэй. Эрэлтийг чанараар хангаж байх брэндийг бүтээдэг. Үүнийгээ хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэлийг тасралтгүй явуулах шаардлагатай. Төрийн болон хувийн хэвшлийнхний нягт харилцаа, хамтын ажиллагаа брэндийг хөгжүүлэх чухал алхам болдог. Брэнд бүтээгдэхүүнд хамгийн ойр байгаа салбар бол ноос, ноолуурын салбар. Бусад салбараас ч

брэнд бүтээгдэхүүн богино хугацаанд гарахыг үгүйсгэхгүй. Гэхдээ дэд бүтэц, логистик болоод холбогдох бусад асуудал цэгцрээгүй байна.

#### **Б.Төмөрчулуу /“Сэргэн мандалд” группын ерөнхийлөгч/:**

Үндэсний бахархал бүтээгдэхүүнийг бий болгохоор Монголын эдийн засгийн чуулганаар хэлэлцэж байна. Дэлхийн эдийн засгийг донсолгох хүчин чадал, үйлдвэрлэлийн боломж Монголд бүрэн бий. Гэвч холч ухаан, урт хугацааны бодлого дутагдаж байна. Эдгээрийг бойжуулж, тордох хэрэгтэй. Гадаад зах зээлд гаргах брэндийг бий болгохын тулд дэлхийн хэмжээний хөрөнгө шаардлагатай. Арилжааны банкны санхүүжилтээр дэлхийн брэнд бүтээсэн түүх үгүй. Зорьж буй үндэсний брэндээ таниулахын тулд төрөөс дэмжлэг харамгүй үзүүлэх нь чухал. Ингэсэн тохиолдолд шаардлагыг өндөржүүлж, өрсөлдөөний талбарыг чөлөөлөх хэрэгтэй. Өнөөдөр олон улс цэвэр хүнсээр дутагдаж байна. Ийм үед хөдөө аж ахуйн орон болох Монгол Улс нөөцөө ашиглан, боломжийн үүдээ нээх хэрэгтэй.

Дэлхийн эдийн засаг гэж төөрөлдөхгүй, дэргэдэх хоёр хөршөө тойрохгүй, Үндэстэн дамнасан

корпорациудын гарт өртөхгүйгээр үндэсний брэндийг бий болгох хэрэгтэй.

#### **Б.Ган-Очир /“Монголын эдийн засгийн чуулган 2013”-ын ерөнхий нарийн бичгийн дарга/:**

Чуулганд төр засгийнхан, хувийн хэвшлийнхэн, иргэний нийгэм, холбоодууд болон төрийн бус байгууллагууд идэвхтэй оролцлоо. Чуулганаар хэлэлцүүлж буй Үндэсний брэндийг бий болгох тал дээр хувийн хэвшлийнхэн түлхүү ажиллах үүрэгтэй. Форумын гол зорилго нь бизнес эрхлэгчдэд нээлттэй байгаа боломжуудыг ойлгуулах, тэдэнтэй арга замын талаар хэлэлцэхэд оршиж байгаа юм. Үүнээс үүдэн хувийн хэвшлийнхэн өөрсдөө үйл ажиллагаандаа хэрэгтэй боломж, хууль эрх зүйн орчин, түүний ойлголтыг олж авах хэрэгтэй. Түүнээс хувийн хэвшлийнхэн хүлээж суух биш, гаргасан үр дүнгээ чуулганаар танилцуулдаг байх хэрэгтэй.

Чаддаг зүйлээ харуулж, түүнийгээ сурталчилах, зөв маркетинг хийж, бүтээгдэхүүнээ илэрхийлэхийг брэнд хэмээж байгаа юм. Дэлхий нийтээр ногоон брэнд рүү хошуурч байна. Байгалийн цэвэр гэх имиж Монголын нэр хүндийг тодорхойлж байгаа энэ үед Үндэсний брэндээ зөв гаргах хэрэгтэй. ■



# MONGOLIA MINING 2013

INTERNATIONAL MINING EXHIBITION AND CONFERENCE

Promoting Responsible Mining

MISHEEL EXPO CENTER

19-20 APRIL, 2013

Ulaanbaatar, Mongolia

[www.mongolia-mining.org](http://www.mongolia-mining.org)

## ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН 3 УУЛ УУРХАЙН ДАХЬ УДААГАА

**БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА**

Нийт табайн **95%** нь захиалагдаад байна. **344488-д** холбогдон талбайгаа амжиж захиалаарай.

Зочин та [www.mongolia-mining.org](http://www.mongolia-mining.org) хаягаар урьдчилан бүртгүүлээд үзэсгэлэнг үнэ төлбөргүй үзнэ үү.

Дэлхийн 15 орны 110 компани уул уурхайд зориулсан тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ 2 өдрийн турш Mongolia Mining 2013 үзэсгэлэнд дэлгэн үзүүлнэ.

Худалдан авагч, ханган нийлүүлэгч, хөрөнгө оруулагч, бизнесийн түнштэйгээ уулзах гайхалтай боломж таныг хүлээж байна.

Цагийн хуваарь:

2013 оны 4-р сарын 19	10.00 – 18.00
2013 оны 4-р сарын 20	10.00 – 17.30

Organized by:



Sponsored by:



Supported by:



CONTACT:

3rd floor, Look Mongolia Building. Chinggis Khaan Avenue 98. Ulaanbaatar 17032, Mongolia  
Tel: 976-11-344488 Fax: 976-11-343757; E-mail: [info@mongolia-mining.org](mailto:info@mongolia-mining.org)

[www.mongolia-mining.org](http://www.mongolia-mining.org)

# ЦЭНХЭР ЭДИЙН ЗАСАГ

## ЭЗОРИГТ

*...Аливаа амьд оршихуйн үүсэл уснаас эхтэй бол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн түлхүүр ч уснаас шууд хамааралтай...*



**М**ах, сүү, арьс шир, ноос, ноолуур гээд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг брэнд болгох боломжтой гэдэгт монголчууд санал нэгдлээ. Хөдөө аж ахуйн салбарын улсын хөгжилд оруулах хувь нэмэр шавхагдашгүй мэт боловч тус салбарын гол баялаг болох байгаль эх тэр дундаа усны асуудал эмзэг гэдгийг бодох хэрэгтэй. Учир нь, хөдөө аж ахуйн салбар байгалийн хүчин зүйлээс шууд хамааралтай. Мал аж ахуйн өнөөгийн дураараа өсгөж, зоргоор нь идээшлүүлдэг байдалд зохицуулалт хийхгүй бол уул уурхайгаас ч илүү хор хөнөөл байгальд учруулж болзошгүй аж. Адаглаад гар худаг гаргах арга технологид малчдыг сургах. Хөдөөгийн хүн ам, 40 сая толгой малыг найдвартай ундны эх үүсвэртэй болгоход төрийн бодлого хэрэгтэй байгааг мэргэжилтнүүд хэлж байна. Ер нь мал аж ахуй төдийгүй бусад эдийн засгийн салбарыг дэмжих үүднээс усыг эдийн засагжуулах учиртай талаар Усны хорооны ажлын албаны дарга Ц.Бадрах хэлсэн юм. Харин үүний тулд монголчуудын дунд “Хөрвөсөн ус”-ны талаарх ойлголтыг бий болгох шаардлага бий.

## Хөрвөсөн ус

Эдийн засгийн чуулганы салбар хуралдааны үеэр “хөрвөсөн ус”

гэдэг монголчуудын төдийгүй дэлхий дахинд шинэхэн ойлголт сөхөгдөв. Үйлдвэрлэгч бүхэн нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ус хэрэглэдэг гэдгээ мэддэг. Гэтэл эцсийн бүтээгдэхүүнийг гаргаж авахын тулд хэчнээн хэмжээний байгалийн ус хэрэглэснээ мэддэггүй. Туул голын сав газрын захиргааны дарга Г.Долгорсүрэн “Дэлхий нийт нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд хэчнээн хэмжээний ус хэрэглэсэн бэ гэдэгт анхаарлаа хандуулж байна. Энэ нь нэг талаар үр ашиггүй усны хэрэглээг багасгах. Нөгөө талаар усыг эдийн засагжуулах гэсэн арга юм. Өнөөдөр монголчууд брэнд бий болгох талаар ярьж байна. Гэхдээ усгүй бол брэнд бий болгож чадахгүй. Тэр дундаа мал аж ахуйн гаралтай брэнд бүтээгдэхүүн бий болгохын тулд ус ямар их шаардлагатайг мэддэггүй. Тухайлбал, олон улсын байгууллагаас гаргасан судалгаагаар Монгол Улс үхрийн мах бэлтгэхэд хамгийн их хөрвөсөн ус хэрэглэдэг гэсэн дүн гарсан байсан” гэв. Энэ нь тухайн үхэр төрөөс эхлээд мах бэлтгэлд очих хүртлээ хэр хэмжээний ус хэрэглэсэн гэдгийг тооцсоны үндсэн дээр гаргасан үзүүлэлт юм. Ер нь “хөрвөсөн ус” хэдий их ашигласан байна төдий чинээ тухайн бүтээгдэхүүний үнэ өндөр байх хандлага олон улсад бий болоод байгаа аж. Энэ хандлагаар бол манай

мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн өндөр үнэтэй байх ёстой.

Монголд “хөрвөсөн ус”-ны талаар мэдлэгтэй үйлдвэр, аж ахуйн нэгж, бодлого тодорхойлогчид хэр олон байгаа бол. Эдийн засгийн хэтийн бодлогыг тодорхойлох, шийдвэр гаргахдаа энэ талаар тусгадаг болов уу. БОНХЯ-наас оны эцэст “хөрвөсөн ус”-ны талаарх дэлгэрэнгүй судалгаа гаргана гэсэн. Цаашдаа үйлдвэрлэл, үйлчилгээ тэр бүүхэл, брэнд бий болгоход хүртэл ус тэр дундаа хөрвөсөн усны үнэ цэнийг боддог болох талаар албаныхан учирласан. Хэрвээ “хөрвөсөн ус”-ны талаарх мэдлэг дээшилбэл усыг эдийн засагжуулахад хялбар болох аж.

## Туулын хөндий дэх соёл иргэншил

Гол усаа дагаж, бас дээдэлж амьдардаг Монгол хүн бүхний сэтгэлийг зовоосон асуудлын нэг нь яах аргагүй хатан Туулын хувь заяа болоод байгаа. Туул гол тасарлаа, сургалаа, бохирдлоо гэж сүүлийн ▶



ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

▶ арав гаруй жил хангалттай ярьсан. Гэтэл дорвитой хийсэн ажил алга. Усыг эдийн засагжуулах талаар ярьж байгаа бол нийслэлчүүдийн усны хэрэглээ, Туул голын хувь заяаг ярих нь зүйн хэрэг. Учир нь, Монгол Улсын ДНБ-ий 60-70 орчим хувь нь тус голын хөндийд үйлдвэрлэгддэг гэдэг.

Туулын амь тасарвал улаан-баатарчууд “цангаж” эхэлнэ. Гэхдээ Монголд усны зөв менежмент, зохистой хэрэглээ бий болгохын тулд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, саарал усны тухай буюу Хот суурин газрын усан хангамж ариутгах татуургын тухай зэрэг хуулийг өнгөрөгч онд баталсан. Гэсэн ч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хуулийг сахин биелүүлэхийн тулд хариуцлагын болоод урамшууллын тогтолцоо оновчтой байх хэрэгтэй гэдэг. Үүний тулд усыг хэн, хэдий хэмжээгээр бохирдуулж байна вэ гэдгийг хэмжих хэрэгтэй. Гэтэл бидэнд хэмжих арга, аргачлал алга. БОНХ-ийн сайдын тушаалаар томоохон голуудын сав газарт захиргаа байгуулсан.

Эдгээр сав газрын мэрэгжилтнүүд голыг бохирдуулж буй буруутанг тогтоодог боловч дээрх журам, заалт дутагдалтай байгаагаас хамаарч таамгаараа торгох болчихдог гэнэ. Гэтэл торгоулах гэж байгаа байгууллага мэрэгжилтнүүдээс торгох талаарх нарийн үнэлгээ шаарддаг ч тэр нь байдаггүй. Энэ талаар Монгол Улсын зөвлөх инженер, доктор Г.Долгорсүрэн “Арьс, ширний үйлдвэр, машин угаалга, үсчин гээд бүх бохирдуулагч өөр. Тиймээс тэдэнд тохирсон төлбөрийн тогтолцоо байх хэрэгтэй. Гэтэл бид энэ талаар тооцоо судалгаа гаргаж чадахгүй байна. Өнөөдөр MCS компани ч юм уу, Харгиа цэвэрлэх байгууламжийн ус ашиглалт дээр анхаарч байна л гэнэ. Гэтэл бид түүнийг нь хэмжиж чадахгүй байгаа. Тиймээс энэ талаарх журам, заалт судалгааг яаравчлан гаргах хэрэгтэй” гэв. Уг нь хуульд заасанчлан Монгол орны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаад, дотоодын ямар ч аж ахуйн нэгж, албан байгууллага усыг зөв зохистой ашиглах учиртай.

Эс бөгөөс өндөр төлбөр төлнө. Аль эсвэл үйл ажиллагаагаа зогсоо гэх хатуухан шаардлага бий. БОНХЯ-ны Усны мониторинг, зохицуулалтын хэлтсийн дарга Г.Мөнх-Эрдэм “Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай хууль батлагдсан. Энэ бол шинэ механизм. Хуульд хэд хэдэн зүйлийг нарийн тусгаж өгсөн байгаа. Нэгдүгээрт, та усанд үрэлгэн технологи ашиглавал тэр хэмжээгээр өндөр төлбөр төлнө. Хоёрдугаарт, ашигласан усаа стандартын түвшинд хүртэл цэвэршүүлж дахин ашиглахгүй бол нэмэгдэл төлбөр төлнө. Тиймээс хуулийн хүрээнд томоохон аж ахуйн нэгж, уул уурхай гэх мэт ус их ашигладаг албан байгууллагууд усыг хэмнэлттэй ашиглах. Тэр усаа дахин ашиглах учиртай” гэсэн юм. Хэрвээ хуулийн хүрээнд ажиллаж чадвал төр төмөр нүүр гаргахгүй. Харин хөнгөлөлт үзүүлнэ. Гэтэл хэнийг нь хэрхэн яаж торгох, урамшуулах талаар дүрэм, журамгүй байгаа өнөө үед нийслэлчүүд ундны усаа нойлдоо татаж, Туул голын амийг тасартал бохирдуулсаар л байх биз ээ. ■

## УСНЫ МЕНЕЖМЕНТ

## Ч.ЛУТАА

...Монголын нэг иргэн 0.6 шоо метр ус хэрэглэж байна. Харин 2021 онд хамгийн ихдээ нэг хүн нэг шоо метр ус хэрэглэнэ гэсэн судалгаа бий. Ийм байхад монголчууд усгүй болох вий гэж айх асуудал алга...

*“Монгол оронд усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх нь” төслийн зөвлөх багийн зохицуулагч Ян Бронтой “Дэлхийн усны өдөр”-ийг угтан ярилцлаа.*

**-Монголчуудын усны хэрэглээний буруу тогтолцоог өөрчлөх цаг болсон талаар олон хүн хэлдэг. Үүний гол шалтгаан нь усны нөөцийн нэгдсэн менежмент байхгүйтэй холбоотой гэдэг. Тиймээс хоёулаа энэ талаар ярилцлагаа эхлэх үү?**

-Сайхан санаа байна. Усны нөөцийн нэгдсэн менежмент /УННМ/ гэж яг юу вэ гэвэл аливаа зүйлийг өөр арга замаар хийхийг хэлнэ. Усны нөөцийн хомсдлоос үүдсэн тэмцэл, зөрчлийг шийдвэрлэхэд анхаарах, зохион байгуулах арга юм. Үүнийг дан ганц тогтсон хэлбэрээр ойлгож болохгүй.

**-Тэгвэл Монголд усны менежментийг хөгжүүлэхэд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?**

-Монгол эрс тэс уур амьсгалтай учраас экосистемүүд нь маш эмзэг, өртөмтхий байдаг. Өвс, ногоо ургах улирал маш богино. Гэтэл сүйтгэгдсэн



ФОТОГ Э.ЗОРИГТ

# ХӨРВӨСӨН УС ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР

байгаль нөхөн сэргэхэд урт удаан хугацаа шаардагддаг. Тиймээс байгалийн усны эх үүсвэр дэх усны чанарыг хамгаалах нь танай орны хувьд чухал асуудал юм.

Мөн Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил цөөн газарт төвлөрөх хандлагатай байна. Нийгэм, эдийн засаг хурдтай хөгжиж буй хот, сууринд усны өөр газраас ус тээвэрлэн авчрах асуудал тулгамддаг. Тиймээс дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Түүнчлэн хот, суурин газарт ахуйн болон үйлдвэрийн бохирдуулагчийн хэмжээ нэмэгдэж, ус байгалиараа цэвэрших боломжгүй болж байна. Тиймээс хүрээлэн буй орчныг нөхөн сэргээгдэх боломжгүй болтлоо бохирдох аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай. Үгүй бол монголчууд ирээдүй хойч үедээ маш өндөр зардал, ихээхэн ачаа үүрүүлэх болно.

**-Та сая манай улсын хөгжил цөөн хэдхэн газар төвлөрч байгаа талаар дурдлаа. Тэгвэл Монголд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой говьд ус санаа зовоосон асуудал болоод байгаа. Энэ тал дээр та юу хэлэх вэ?**

-Мэдээж говьд явагдаж буй уул уурхайд их хэмжээний ус шаардлагатай бөгөөд эдгээр хэрэгцээг хангах усны нөөц нь газрын доорх гүний уст давхрагууд. Эдгээр давхарга үл сэргээгдэх геологийн уснаас бүрддэг. Түүнчлэн ус нь чанарын хувьд төдийлэн сайн биш. Ийм төрлийн усыг уул уурхайд яагаад ашиглаж болохгүй гэж. Яг үнэндээ уул уурхай тийм ч

их ус хэрэглээд байдаггүй. Уурхайд ашигласан усанд тодорхой хөрөнгө оруулалт хийснээр эргэн ашиглах боломжтой. Усыг дахин ашиглах системийг нэвтрүүлж чадвал газрын доорх усыг ашиглахад өртөг зардал тийм ч өндөр биш. Мөн энэ төрлийн усыг ахуйн зориулалтаар ашиглаад байдаггүй шүү дээ.

Говийн малчдын унд, ахуйн зориулалтаар хэрэглэдэг гүехэн уст давхаргатай, уурхайн хэрэглэх гүний уст давхаргууд ихэнхдээ холбогдогдоогүй байдаг. Гэхдээ говь нутгийн геологи гэдэг адармаатай. Гүний уст давхаргуудаас уул уурхайн зориулалтаар ус ашиглаж байгаа нь орон нутгийн хувьд гүехэн уст давхаргуудын усны түвшинд нөлөөлөх магадлалтай тул хяналт тавих шаардлагатай.

**-Монголын газрын гүний усны нөөц бага. Гэтэл тэр нөөцөө хайр гамгүй хэрэглэдэг. Гадаргын усны нөөц их боловч ихэнх нь хилээр гараад явчихдаг гээд олон шүүмжлэл байдаг шүү дээ.**

-Эдгээр нь ярих ёстой асуудал. Гэхдээ нэг Монгол хүнд жилд ногдох усны хэмжээ 10.000 шоо метр байна. Энэ дэлхийн хамгийн өндөр үзүүлэлтийн нэг. Гэтэл өдгөө Монголын нэг иргэн 0.6 шоо метр ус хэрэглэж байна. Харин 2021 онд хамгийн ихдээ нэг хүн нэг шоо метр ус хэрэглэнэ гэсэн судалгаа бий. Ийм байхад монголчууд усгүй болох вий гэж айх асуудал алга. Харин дээр дурдсанчлан Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хурдацтай хөгжил цөөн хэдхэн газар төвлөрч тэнд усны гачигдал үүсэхтэй холбоотой өөр газраас ус тээвэрлэх асуудал тулгамдаж байгаа юм.

Тиймээс нийслэлчүүд усыг дахин ашиглах “саарал ус”-ны үнэ цэнийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

**-Монголчуудын дунд “саарал ус”-ны талаарх ойлголт сайн биш. Тухайлбал, нойлдоо ундны усаа татах жишээтэй. Хэдий саарал усны тухай хууль батлагдсан ч энэ муу зуршлаасаа салаагүй л байна.**

-Өдөр тутам хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд усыг их, бага хэмжээгээр ашигладаг. Үүнийг “виртуал ус” буюу тухайн бүтээгдэхүүнд “хөрвөсөн ус” гэж томъёолдог. Хөрвөсөн ус нь ус ашиглалт болон бохирдлын хэмжээг мөн тодорхойлно. “Хөрвөсөн ус”-ыг дотор нь “цэнхэр ус”, “ногоон ус”, “саарал ус” гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгт хуваадаг. “Цэнхэр ус” гэдэг нь цэнхэр өнгөтэй усны нөөц (нуур, гол мөрөн, мөсөн гол, газрын доорх уст давхарга гэх мэт усны эх үүсвэрүүдэд хадгалагдаж буй ус)-ийг хэлнэ. “Ногоон ус” гэдэг нь ногоон усны нөөц (борооны ус хөрсний чийгшил хэлбэрээр хадгалагдаж, өвс, ургамлыг тэжээдэг) ууршсан усыг хэлнэ. “Саарал ус” гэсэн ойлголтод бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд үүсдэг бохирдлын талаар авч үздэг. Ахуйн ус хангамжийн зориулалтаар ашигласан маш их хэмжээний бохир усыг эргээд усан орчин руу нийлүүлдэг. Мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ихээхэн хэмжээний бохирдол үүсдэг. Тэгэхээр “саарал ус”-ны хэрэгцээг дээр дурдсан бохирдуулагчдын концентрацийг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэршүүлэн шингэрүүлэхэд»

шаардагдах цэвэр усны хэмжээгээр тодорхойлж болно. Тухайлбал, жинсэн өмдийг үйлдвэрлэхэд 6000 л ногоон ус, 3600 л цэнхэр ус шингэсэн байдаг. Үйлдвэрлэлээс үүдсэн бохирдуулагчдын концентрацийг стандарт хэмжээнд хүртэл шингэрүүлэхийн тулд дахин 1400 л цэвэр ус шаардагдах бөгөөд үүнийг “саарал ус” гэж нэрлэдэг. “Хөрвөсөн ус”-ны нөхцөлөөр тодорхойлогдож буй “саарал ус”-ыг бохир усны нөхцөлд хамаатах “саарал ус”-тай андуурч болохгүй гэдгийг хэлэх нь зүйтэй.

**-Ялгаатай гэдгийг хүмүүс тэр бүр мэддэггүй.**

“Саарал ус” гэдэг нь аливаа бохирдол усны хүрэлцээт байдалд хэрхэн нөлөөлдөг болохыг тоо хэмжээний нөхцөлөөр тодорхойлдог онолын ойлголт юм. “Саарал ус” бол бохирдлын концентрацийг стандарт түвшинд шингэрүүлэн цэвэршүүлэхэд шаардагдах цэнгэг, цэвэр усны хэмжээ. Тиймээс ч усны нөөцийн томоохон хэсгийг иймэрхүү зориулалтаар ашиглах хэрэгцээ гардаг. Байгаль руу нийлүүлэхээс өмнө бохир усанд цэвэрлэгээ хийх нь саарал усны хэрэгцээг бууруулахын зэрэгцээ өөр зориулалтаар ашиглахад хүрэлцээтэй усыг үлдээж буй хэрэг юм. Тухайн орон нутгийн онцлогоос шалтгаалан энэ төрлийн саарал усны хэрэгцээ цэнхэр усны хэрэгцээнээс их байдаг. Тухайлбал, 10 дахин их байх тохиолдол ч бий. Тиймээс саарал усны тухай ярихын тулд хөрвөсөн усны талаар ойлголттой болох хэрэгтэй. Бидний өдөр тутам хэрэглэдэг зүйлсийг үйлдвэрлэхэд ашигладаг бүхий л төрлийн усыг нэмбэл бидний хэрэглээний хөрвөсөн усны хэмжээг тооцоолох боломжтой болно.

**-Манай орны цэнхэр усны ашиглалт, нөөц ямар хэмжээнд байна вэ?**

-Зөвхөн Монгол орны хэмжээнд ашиглагдаж буй “цэнхэр ус”-ыг авч үзэхэд ахуйн ус хангамж нь дотоодын “цэнхэр ус”-ны нийт хэрэглээний таван хувийг эзэлж байна. Үүнд боловсон жорлон багтах бөгөөд тухайн таван хувийн бутархай тоон хувийг эзэлж байгаа юм. Орон гэртээ усыг ариг гамтай хэрэглэх, хэвшүүлэх ёстой. Хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд тавих үед ахуйн болон үйлдвэрийн бохир усны цэвэрлэгээ нь саарал усны бүрэлдэхүүн хэсгийг ихээхэн хэмжээгээр бууруулах боломжтой. Ялангуяа ахуйн бохир усыг дахин ашиглахад гарч болох үр дүнгээс хамгийн багадаа 10 дахин их хэмжээгээр ч бууруулах боломжтой. Нэг зүйлийг сонирхуулахад монголчуудын бүх төрлийн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнд “хөрвөсөн ус”-ны 93 хувийг “ногоон ус” эзэлдэг байна. “Ногоон ус” ямар ч байсан уурших нь тодорхой бөгөөд малын идэш тэжээлээс өөр ямар ч зориулалтаар ашиглагдах боломжгүй. Ашиглахгүй байлаа ч гэсэн ууршаад л алга болчихно. Эцэст нь хэлэхэд “хөрвөсөн ус” хэмээх ойлголт нь та бид байгаль дэлхийн усны нөөцийг хэрхэн ашиглаж байгаагаа ойлгоход маш их хувь нэмэр оруулж байдаг юм шүү. Ямартай ч эдгээр жишээнээс харахад монголчуудын усны хэрэглээ тартагтаа тулчихаагүй. Тиймээс аль болох эртнээс усны зөв зохистой хэрэглээнд анхаарлаа хандуулах нь ирээдүйдээ хийх маш том хөрөнгө оруулалт юм. ■





# ХАНДЛАГА

Жилд дунджаар 6-7 сая хүн усны гамшиг болон устай холбоотой өвчний улмаас нас бардаг.

Хүн амын өсөлтийн төсөөллөөс харахад, ирэх 40 жилд хүн ам 2-3 тэрбумаар нэмэгдэх бөгөөд тэдний хоолны зуршил өөрчлөгдөнө гэж тооцвол 2050 он гэхэд хүнсний хэрэгцээ 70 хувиар нэмэгдэх ажээ.

Бөмбөрцгийн хүмүүсийн тэн хагас нь хот, суурин газарт амьдардаг бөгөөд тэдгээрийн тоо өдөр ирэх тусам нэмэгдэж байна. Хөдөө, орон нутгийг бодвол хоол, ундны хангамж илүү сайн боловч өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах гэж байдгаараа хичээж байна (ДЭМБ/НҮБ-ын Хүүхдийн сан 2010 он).

2030 он гэхэд хүн амын өсөлтөөс гадна хүнсний хэрэгцээ 50 хувиар нэмэгдэх төсөөллийг гаргажээ (Бруинсма, 2009 он). Харин усны болон сэргээгдэх эрчим хүчнээс гарган авах эрчим хүчний хэрэгцээ 60 хувиар өсөх төлөвтэй байна (Дэлхийн усны үнэлгээний хөтөлбөр, 2009 он). Эдгээр асуудал өөр хоорондоо уялдаа холбоотой. Тухайлбал: хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлбэл үүнийг дагаад ус, эрчим хүчний хэрэглээ огцом нэмэгддэг. Энэ нь ус ашиглагч салбаруудын хоорондох өрсөлдөөнийг улам хурцатгадаг.

Усны хүрэлцээ, хангамж багасах хандлагатай байна. Дэлхийн хөдөө аж ахуйн салбарын цаашдын усны хэрэглээ 2050 онд ойролцоогоор 19 хувиар нэмэгдэх тооцоо гаргажээ.»

нөөцийн тогтвортой менежментийг олон нийтээр дэмжүүлэхэд анхаарлаа хандуулахад оршино.

Жил бүрийн энэ өдөр цэвэр усыг өвөрмөц онцлогуудаар нь тусгайлан авч үздэг байна. Энэ оны хувьд “Олон улсын усны хамтын ажиллагаа” гэсэн үндсэн уриан дор зохион байгуулж буйгаараа онцлог юм.

## Өдөр бүр нэмэгдэж буй усны хэрэгцээ

Нийт хүн амын 85 хувь нь дэлхийн тэн хагас болох хамгийн хуурай, цөлжилттэй бүс нутагт амьдардаг.

780 гаруй сая хүн өнөөдөр цэвэр ус хүртэх боломжгүй байгаа бол ойролцоогоор 2.5 тэрбум хүнд ариун цэврийн байгууламж хүрэлцэхгүй амьдарч байна.

Р.ГАНТУЛГА

## Дэлхийн усны өдөр

НҮБ-ын “Байгаль орчин, хөгжил” сэдэвт бага хурлаар 1992 онд цэвэр усны олон улсын өдрийг тэмдэглэж байх саналыг анх гаргасан бөгөөд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас 1993 оны гуравдугаар сарын 22-нд Дэлхийн усны өдрийг тэмдэглэж байхаар шийдвэрлэжээ. Гол зорилго нь цэвэр усанд ач холбогдол өгч, цэвэр усны


- ▶ Гэхдээ энэхүү урьдчилсан тооцоонд технологийн олон янзын үйл явц болон бодлогын хөндлөнгийн оролцоог оруулаагүй байна.

Усалгаатай тариалан болон хүнсний үйлдвэрлэл нь цэвэр усны нөөцөд үзүүлэх хамгийн том дарамт, шахалтын нэг юм. Хөдөө аж ахуйн салбар дэлхийн цэвэр ус ашиглалтын 70 гаруй хувийг эзэлдэг (хурдацтай өсч буй зарим эдийн засгийн 90 хүртлэх хувийг эзэлдэг).

Эдийн засаг улам өсч, хувь хүмүүс ихээр хөрөнгөжих

### 1994-2012 онд дэлхийн усны өдөр ямар уриатай болж байсныг сонирхуулъя.

2012 – Ус ба хүнсний аюулгүй байдал  
 2011 – Хотуудын ус  
 2010 – Усны чанар  
 2009 – Хил дамнасан ус  
 2008 – Олон улсын ариун цэврийн жил  
 2007 – Усны хомсдол  
 2006 – Ус ба соёл  
 2005 – Амьдралын ус 2005-2015  
 2004 – Ус ба байгалийн гамшиг  
 2003 – Ирээдүйн ус  
 2002 – Хөгжилд зориулсан ус  
 2001 – Эрүүл мэндэд зориулсан ус – Хариуцлага  
 2000 – Хорин нэгдүгээр зууны ус  
 1999 – Бүх хүн усны урсгал дор амьдардаг  
 1998 – Газрын доорх ус – Нүдэнд үл үзэгдэх нөөц  
 1997 – Дэлхийн ус – Бидэнд хангалттай юу?  
 1996 – Цангасан хотуудад зориулсан ус  
 1995 – Эмэгтэйчүүд ба ус  
 1994 – Усны нөөцөө анхаарах нь хүн болгоны үйлс



болсон нь хүмүүсийн хоолны зуршлыг өөрчилж, цардуул голчилсон хоол хүнс байснаа мах, сүүн бүтээгдэхүүн рүү шилжих болсон учраас усны хэрэгцээ үүнийг дагаад улам нэмэгдэх болжээ. Тухайлбал, нэг кг цагаан будааг үйлдвэрлэхэд 3500 л ус, мөн хэмжээний үхрийн махны үйдвэрлэлд 15000 л ус, аяга кофенд 140 гаруй л ус тус тус шаардагддаг (Хоекстра, Чапагейн нар 2008 он). Хоол, хүнсний хэрэглээнд гарсан энэхүү өөрчлөлт нь сүүлийн 30 гаруй жилийн туршид усны хэрэглээнд хамгийн их нөлөө үзүүлсэн байна. Энэ хандлага XXI зууны дунд үе хүртэл бүр ч эрчимтэй үргэлжлэх төлөвтэй байгаа юм.

Африк тивийн 66 орчим хувь нь цөлжсөн хуурай газар нутагтай бөгөөд Сахарын цөлийн өмнөд хэсэгт байрлах Африкийн хойд хэсэгт амьдардаг 800 гаруй сая хүн амын 300 сая нь усны гачлантай амь зууж байна. Жилд нэг хүнд ногдох усны хэмжээ 1000 шоо метрээс ч бага ажээ (NEPAD-Африкийн хөгжлийн шинэ түншлэл 2006 он).

## Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл

Олон улсын ургамал хамгаалах конвенц (IPPC)-оос гаргасан төсөөллийн дагуу усны стресс Төв болон Зүүн Европт улам нэмэгдэж, 2070 он гэхэд энэ нөлөөлөлд автах хүмүүсийн тоо 28-44 сая хүртэл нэмэгдэх ажээ. Зуны урсац Өмнөд Европт, Төв болон Зүүн Европын зарим хэсэгт 80 хүртлэх хувиар нэмэгдэх хандлагатай. Европын усны эрчим хүчний нөөц бололцоо дунджаар зургаан хувиар багасахаар байгаа бол Газрын дундад тэнгис хавьцаа 2070 он гэхэд 20-50 хувиар нэмэгдэх хандлагатай (Алкамо ба бусад, 2007 он).

Дэлхийн дундаж температур цельсийн хоёр хэмээр нэмэгдэхэд үүсэх уур амьсгалын нөлөөлөлд дасан зохицоход шаардагдах зардал 2020-2050 онд 70-100 тэрбум ам.долларт хэлбэлзэх хандлагатай (Дэлхийн банк, 2010 он). Үүний 13.7-19.2 тэрбум ам.доллар нь (услуг ихтэй хувилбараар тооцоход) устай холбоотой зардал байх бөгөөд үүнд ус хангамж болон үерийн менежмент давамгайлахаар байгаа юм.

## Усны бохирдол

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-д 14 орон гишүүнчлэлтэй байдаг бөгөөд бохир усыг цэвэрлэх үүрэг хүлээсэн байдаг. Харин тус байгууллагын гишүүн бус орнууд бохир усыг багахан хэмжээнд цэвэрлэх юм уу, аль эсвэл огт цэвэрлэдэггүй байна. Бохир усыг цэвэрлэхэд тодорхой хэмжээний эрчим хүч шаардагдах бөгөөд уг эрчим хүчний хэрэгцээ дэлхийн хэмжээнд ялангуяа гишүүн бус орнуудад 2006-2030 онд 44 хувиар нэмэгдэх хүлээлттэй байна (IEA, 2009 and Corcoran et al., 2010).

Усны бохирдолд хил хязгаар гэж байдаггүй. Хөгжиж буй орнууд бохир усныхаа 90 хүртэлх хувийг цэвэрлэлгүйгээр гол мөрөн, нуур болон өндөр бүтээмжит эрэг хавийн бүсүүдэд хаяж байгаа нь хүний эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, баталгаат унд, ахуйн усанд аюул учруулж буй хэрэг юм. Дэлхийн хэмжээнд хэрэглэсэн усны 80 гаруй хувийг хуримтлуулж, цэвэршүүлдэггүй байна (Corcoran et al., 2010)

## Хамтын ажиллагаа

Усны төлөөх зөрчил, тэмцлээс илүүтэйгээр хил дамнасан усны хамтын ажиллагааны эх үүсвэрийг харуулах жишээ цөөнгүй. Ерөнхийдөө 1890-2007 оны хооронд олон улсын усны тухай 450 орчим гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурсан байдаг (OSU, 2007).

Африк тивийн усны сав газруудын хамтран ашиглалтыг дэмжих үүднээс олон улсын усны тухай 90 гаруй гэрээ, хэлэлцээрийг боловсруулж байжээ (НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, 2010 он). ■

# УС ЮУ БҮТЭЭДЭГ ВЭ

Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулахад зарцуулах усны хэмжээ

**1 ш A4 цаас:**  
**10 л**

**1 хэрчим талх:**  
**40 л**

**1 ш өндөг:**  
**140 л**

**Хос ширэн гутал**  
**8,000 л**

**Хөх жинсэн хослол**  
**11,000 л**

**1 кг үхрийн мах**  
**15,400 л**

**1 машин**  
**150,000 л**

## Улаанбаатар хотын усан хангамжийн одоогийн байдал

Усны эх үүсвэр	4
Дамжуулан шахах насосны станц	10
Төв шугамд	3
Гэр хорооллын шугамд	7
Гүний худаг	170
Гэр хорооллын ус түгээх байр	568
ЗУХА (автомашинаар зөөвөрлөхөд)	250
СНА (шугамаар түгээдэг)	318
Цэвэр усны шугамын урт, км	350.1
Гэр хорооллын цэвэр усны шугамын урт, км	173.0
Хоногт олзворлон түгээж буй усны хэмжээ, мян м3	150.0-169.0
Цэвэр усны шугамын диаметр, мм	100-800
Цэвэр усны шугамын материал	ган, ширэм, хуванцар
Анхны цэвэр усны шугамын ашиглалтанд орсон хугацаа	1959 он
Цэвэр усны шугамын насжилт	2-52 жил

ОЮУТОЛГОЙН БУЛАН

# УХААЛАГ ХЭМНЭЛТ

Б.БАЯРТОГТОХ

*...“Оюутолгой”-д юу үнэ цэнэтэй вэ. Мэдээж хүн, ус. Тус компани нийт усны хэрэглээнийхээ 84 хувийг дахин ашиглах бөгөөд 16 хувийг газрын доорхи уснаас авч ашиглахаар төлөвлөж байгаа аж...*

Бидний өвөг, дээдэс дэлхийн талыг эзэлж явсан ч далай тэнгист халдаж зүрхэлдэггүй байж. Наран улсыг эзлэхээр далайг гатлах гэж хоёр удаа оролдсон ч мөнх тэнгэр ивээгээгүй. Морин туурайгаар хуурай газрыг тамгалсан Чингис хаан “Үүнээс цааш газар үгүй” хэмээн өгүүлсэн нь түүх болон үлджээ. Үүнээс өөр далай, тэнгистэй хийсэн тэмцэл бидэнд үгүй. Өөрөөр хэлбэл, эх газрын элгэнд буй Төв Азийн Монгол далайн чанадад нэвтэрч чадаагүй нууц нь энэ. Номхон далайд тулж, Атлантын далайгаас буцаж, Энэтхэгийн далайн захад түр амсхийсэн бидний өвөг, дээдэс усыг тэнгэр мэт шүтэж явжээ. Урьдын түүхийг нийтлэлийнхээ тэргүүнд онцлоё. Чингис хаан аян дайнд мордож гэнэ. Замд цэргүүд нь хатаж цангахын даваан дээр нэгэн гол таарчээ. Голын зүг амь тавин гүйх цэргүүдээ хараад Чингис хаан “Голын уснаас амаараа ууж байгааг нь орхи, алгаараа тосон ууж байгааг нь цааш авч яв” хэмээн жанжиндаа хэлсэн байна. Учир нь монгол хүн үхэх гэж байсан ч өөрийгөө болон байгаль дэлхийгээ хүндэтгэх ёстой. Усанд нохой шиг амаа дүрэх нь дайчин эр хүний шинж биш гэж үзсэн байна.

Оюутолгой, Тавантолгой, Цагаан суварга, Төмөртэй, Мардай, Асгатын амин чухал хэрэгцээ нь ус. Тиймээс ус бол стратегийн чухал түүхий эд. Усгүйгээр олборлолт, үйлдвэрлэл, амьдрал тэнд өрнөхгүй. Уурхай битгий хэл, улс оршин тогтнох баталгааны нэг нь ус. Хэрэв өмнийн говьд усны нөөц тун ховор байсан бол Тавантолгойг нээх шалтгаан Монголын төрд үгүйсэн.

Цэвэр усны нөөц цэнхэр дэлхийд ядмагхан. Гэсэн ч түүнийг ариглан хэмнэж чадвал бидний үе, удам зуун зууныг элээх заяатай. Иймээс НҮБ-аас 2013 оныг “Усны хамтын ажиллагааны жил” болгон зарласан. Манай дэлхий олуулаа болж, хөгжин дэвших хил хязгааргүй хүсэлд автах тусам усны хэрэглээ тэлсээр байна. Ирэх 15 жилд өмнөд говийн бүсийн усны хэрэглээ 10-20 дахин нэмэгдэх судалгаа гарчээ.

Монгол Улс өнөөгийн байдлаар жилд 552.65 сая, өдөрт 1.5 сая орчим шоо метр ус хэрэглэж байгаа бөгөөд 42.9 хувийг нь уул уурхай, эрчим хүч, боловсруулах үйлдвэрлэлд, 12.9 хувийг хүн амын ундны хэрэгцээнд ашиглаж байна. Ерөнцийн хүн амын 60 хувь нь амьдрах Ази тив дэлхийн усны хэрэглээний 36 хувийг эзэлдэг. Үүний нэг хэсэг нь монголчуудад ногдож буй. Дэлхийн цаг уурын өөрчлөлт нь далай тэнгисээс алслагдсан Хятадын хойд хэсэг, Монголын говь, Дундад Азийн Кара Кум, Сахарын цөл, Аризон, Калифорны хуурай бүс нутаг, Ойрхи Дорнод, Саудын Араб, Австралийн цөлөрхөг газруудад илүү мэдрэгдэж байна. Ус бол санхүүгийн хэрэгсэл. Тиймээс байгальд ээлтэй технологи, шинэ менежментийг нэвтрүүлэх шаардлага үүсэх боллоо.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад нэг шоо метр усны борлуулалтын үнэ дунджаар 1900 төгрөг, хөгжиж буй орнуудад 2500 төгрөг байгаа бол манай оронд усны үнэ дунджаар 610 төгрөгийн үнэ цэнэтэй байна. Нэг үгээр хэлбэл, усны үнэлэмж асар бага байгааг илтгэсээр. Нэгэн сонирхолтой

жишээ өгүүлэхэд, өнгөрсөн 50 жилийн хугацаанд улс гүрнүүдийн хооронд устай холбоотой 1831 удаа маргаан дэгдэж байж. Дэлхийн цэвэр усны хэрэглээ жил тутам хоёроос дээш хувиар өсч байгаа нь 21 жил тутамд хоёр дахин өсч байна гэсэн үг. Иймээс усны асуудалд улс төржих бус ухаалаг хэмнэлт хийх цаг болсныг дахин сануулъя.

## “Оюутолгой”-д юу үнэ цэнэтэй вэ...

“Оюутолгой” компанийн Хувь нийлүүлэгчдийн хурал үргэлжилж байна. Зургаа дахь удаагийн ээлжит хуралд Монголын Засгийн газраас зургаан гол асуудлыг гарган тавьсан. Мөн “Оюутолгой” компанийн ТУЗ-д шийдвэрлүүлэх 13 асуудлыг хөндсөн. Түүний нэг нь усны хангамж.

Өмнийн говийн бүсийн усны эрэлт, хэрэгцээ сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тавантолгой, Оюутолгой ордыг дагасан дэд бүтэц, бүтээн байгуулалтад шаардлагатай усны эрэлд мордох ▶





болсон. Тиймээс Оюутолгойг тойрсон бүлэг ордуудын усны асуудал хэзээд олон нийтийн анхаарлын төвд байсаар. Тэгвэл “Оюутолгой”-д юу үнэ цэнэтэй вэ. Мэдээж хүн, ус. Тус компани нийт усны хэрэглээнийхээ 84 хувийг дахин ашиглах бөгөөд 16 хувийг газрын доорхи уснаас авч ашиглахаар төлөвлөж байгаа аж. Компанийн зүгээс Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвд шинэ усны эх үүсвэрийг нээх, худаг гаргах, шаардлагатай судалгаанд 1.7 тэрбум төгрөгийг зарцуулсан дүн мэдээ гарчээ. Мөн усны тогтвортой нөөцийг бий болгох зорилгоор нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж байгаа аж. Уг төслийн хүрээнд усыг дахин цэвэршүүлэн үйлдвэрлэлд ашиглах бөгөөд Даланзадгад, Баян-Овоо сумдад усны эх үүсвэр хайхад 300 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Компани усыг аль болох ухаалаг, үр ашигтай ашиглахаар ажиллаж байгаа аж. Дашрамд өгүүлэхэд, Оюутолгой төсөл нь дэлхийн ижил төстэй бусад уурхай дотроо усыг хамгийн үр ашигтай ашиглаж буйд багтдаг юм байна.

## Дэлхийн стандарт Монголд

Монголын нэн шинэ үеийн уул уурхайн салбарт ахиц гарч байгааг онцлон тэмдэглэе. Оюутолгой компани хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон байгаль орчны олон улсын ISO 14001, OHSAS 18001 стандартыг нэвтрүүлсэн чухал үйл явдал энэ сарын 14-нд боллоо. Олон улсын ISO 14001 стандартын шаардлагад нийцсэн удирдлагын тогтолцоог “Оюутолгой” компани 2010 оноос боловсруулсан бөгөөд өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Det Norske Veritas (DNV) компанийн хөндлөнгийн аудитын дүгнэлтээр баталгаажуулалтын гэрчилгээ авчээ. Уг DNV баталгаажуулалтын байгууллага нь Норвеги улсад анх байгуулагдсан, дэлхийн 100 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг Австрали-Шинэ Зеланд улсын хамтарсан ASNZ итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлэгдсэн аж.

Усны асуудлыг хөндөж буй өнөө үед олон улсын стандартын болзлыг Оюутолгой төсөл хангаж байгаа нь олзуурхуштай.

“Оюутолгой” компанийн дэд ерөнхийлөгч Айвен Вема “Оюутолгой компани нь хоёр сарын өмнө баяжмалаа гарган авч бүтээн байгуулалтын ажлаас үйлдвэрлэлд шилжсэнээ зарлаж байсан бол өнөөдөр олон улсын хамгийн шилдэг стандартуудыг нэвтрүүлж гэрчилгээгээ авсан мэдээллийг та бүхэнд хүргэж байна. Энэ амжилт бол манай үндсэн болон гэрээт ажилтан бүрийн хичээл зүтгэлийн үр дүн. Бид эдгээр тогтолцоог бий болгосноор эрүүл мэнд аюулгүй ажиллагаа болон байгаль орчны үйл ажиллагааг хянаж, удирдах замаар эрсдэлийг бууруулах, ажлын гүйцэтгэлийг байнга сайжруулах ач холбогдолтой” гэв. Монгол Улсад дээрх стандартыг нэвтрүүлсэн нь уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр юм байна. Хариуцлагатай уул уурхайн сайн соёлыг Монголд түгээн дэлгэрүүлж буй “Оюутолгой” компани гэж DNV үнэлжээ.

Байгаль орчны удирдлагын ISO 14001, аюулгүй ажиллагааны OHSAS 18001 стандарт нь хариуцлагатай ажиллах, эрсдэлийг удирдах үндсэн нөхцөл болдог аж. “Оюутолгой” компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРей “Оюу Толгой компани олон улсын хамгийн шилдэг стандартуудыг нэвтрүүлж, гэрчилгээгээ авлаа. Энэ амжилт бол манай үндсэн болон гэрээт ажилтан бүрийн хичээл зүтгэлийн үр дүн. Бид эдгээр тогтолцоог бий болгосноор эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хянаж, удирдах замаар эрсдлийг бууруулах, ажлын гүйцэтгэлийг сайжруулах ач холбогдолтой. Мөн энэ бол монгол хүн бүрийн бахархах амжилт юм” хэмээн онцлов. ■

# ДЭЛХИЙН СОНГОДОГИЙГ МОНГОЛЫН СОНГОДОГТОЙ ХОСЛУУЛСАН ТАНСАГ ҮДЭШ БОЛОВ

Английн Land Rover корпорацийн Монгол дахь цорын ганц албан ёсны эрхт дистрибьютер Вагнер Ази Автомотив компани Монголынхоо хэрэглэгчдэд зориулж 2013 оны дөрөв дэх үеийн цоо шинэ Range Rover машиныг 2013 оны гуравдугаар сарын 1-ний өдөр Сүхбаатарын талбайд танилцууллаа.



Гадаа, дотор гэсэн хоёр хэсгээс бүрдсэн Range Rover автомашиныг танилцуулах нээлтийн арга хэмжээг ДБЭТ-т зохион байгуулж, хүндэтгэлийн хүлээн авалт, сонгодог аясаар чимжээ.



Гадаад, дотоодын хүндэт 350 гаруй зочдын хөлд дарагдсан энэ үдэш МУГЖ Э.Амартүвшин, С.Мөнгөнцэцэг, СТА Ө.Уянга зэрэг дуурийн алдартнууд уригдан ая дуугаа өргөснөөс гадна П.И.Чайковский, Иоганн Штраус зэрэг дэлхийн алдарт хөгжмийн зохиолчдын сонгодог бүтээлүүд үдшийг улам ч үнэ цэнэтэй, эрхэмсэг болгосон юм.

2013 оны Range Rover автомашины бүх бие хөнгөн цагаан материалаар хийгдсэн тул жин нь 400 гаруй килограммаар багасч бусад автомашинтай харьцуулахад цохилтын хүчийг хоёр дахин өөртөө шингээж ослын үед жолооч, зорчигчдыг бэртэл гэмтлээс хамгаалах маш том давуу тал болсон аж.



Range Rover автомашин 10 гаруй жилд нэг л удаа бүрэн шинэчлэгддэг. 2013 оны загвар нь энэхүү шинэчлэлийн дөрөв дэх үеийн анхны загвар бөгөөд түүнийг хэрхэн өөрчлөгдсөнийг харуулах зорилгоор өмнөх гурван загварыг хажууд нь дэлгэн тавьсан байлаа.



Техник, технологи, аюулгүй байдал, зорчигчдын тав тух, Монголын хот хөдөө, өвөл зуны улиралд таарсан, бартаа саад ихтэй замд явахад бүрэн нийцсэн жийп ангиллын автомашин мөн гэдгийг Land Rover корпорацийн Ази Номхон Далайн бүсийн захирал Дейл Жонс баталж байв.



ЭЛЧИН САЙД

# ГАРАА НЭГТЭЙ ОРНУУД

## Б.ЭНХЦЭЦЭГ

*...Чөлөөт худалдааны үр дүнд бид томоохон өөрчлөлтүүдтэй зохицох хэрэг гарсан. Бүхэл бүтэн салбар арчигдсан ч өөр нэгэн цоо шинэ салбар хүч түрэн гарч ирсэн юм. Бидний устана хэмээн хүлээж байсан салбар харин ч илүү хүчирхэгжсэн...*

**М**онгол-Канадын дипломат харилцаа тогтоосны 40 жил, Улаанбаатарт Канадын Элчин сайдын яам байгуулсны таван жилийн ой энэ онд тохиож буй. Манай улсын хоёр дахь том хөрөнгө оруулагч Канад улсын Монголтой харилцах харилцаа, хамтын ажиллагаа уул уурхайгаас хэдийнэ давжээ. Тиймээс манай сэтгүүл Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Грегори Голдхаукыг энэ удаагийн “Элчин сайд” буландаа урьж, ярилцсан юм. Тэрбээр 2010 оноос Монгол Улсад Элчин сайдаар ажиллаж, амьдарч байна.

**-Ямар тохиолоор энэ цаг үед таны ажил, амьдрал Монголтой**



ФОТОГ Э.ЗОРИГТ

### холбогдов?

-Хүүхэд байхаасаа улс үндэстнүүдийн аж байдлыг ихээхэн сонирхдог байлаа. Олон улсыг бизнесийн талбартай холбон ажиллах нь миний хүсэл байв. Төрийн алба, гадаад хэрэг болон олон улсын худалдааны чиглэлээр тус тус ажиллаж байсан. Улмаар 1981 оноос Засгийн газраа төлөөлөн дэлхийн бусад улсад дипломатчаар ажиллаж байна. Баялаг түүхтэй монгол оронд

ажиллаж, амьдарч буйдаа баяртай байна.

**-Үүрэгт ажлаа авахын өмнө Монголд амьдрахад тулгарч болох сорилтуудыг хэрхэн төсөөлж байсан бэ?**

-Хоёр орны хоорон дахь харилцаа өргөжин тэлж байгаагийн зэрэгцээ Монгол Улс хурдацтай өсөн дэвжиж буй энэ үед ирж ажиллана гэдэг миний хувьд сэтгэл хөдлөм байх ч нөгөө талаас ажил мэргэжлийн»

▶ хүрээнд томоохон сорилт болно гэдгийг анхнаасаа мэдэж байсан.

Хүрээлэн буй орчин, цаг агаарын өөр нөхцөлөөс үүдэн гэр бүлээ Монголд идээших эсэхт санаа зовниж байлаа. Гэсэн ч миний охин сургуульдаа дуртай, гэргий минь эндхийн урлагийнхантай дотно харилцаатай ажилладаг болсон болохоор санаа зовох зүйл алга. Улаанбаатар бол бидний гэр. Эх орондоо очих сайхан ч гэртээ эргээд ирэх бүр ч сайхан.

**-Канад улс Монгол дахь хөрөнгө оруулалтын хэмжээгээр хоёрдугаарт жагсдаг. Манай хоёр орны хамтын ажиллагааны гол суурь нь юу вэ?**

-Харилцаа, хамтын ажиллагааны гол суурь нь худалдаа. Үүний дийлэнхийг уул уурхайн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт эзэлж байна. Статистик мэдээллээр Канад улсын 30 орчим компани Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг. Үүнд ханган нийлүүлэгчид ч хамаарна. Бидний судалгаагаар манай улсын Монгол дахь хөрөнгө оруулалтын хэмжээ таван тэрбум ам.доллартай дүйж буй.

Манай хоёр улсын бүтээгдэхүүн, үйлчилгээ тэргүүтэй худалдааны харилцаа ойрын жилүүдэд өсөн нэмэгдэж байна. Өнгөрсөн жил л гэхэд огцом буюу 200 хувиар өссөн байгаа юм. Бараа, бүтээгдэхүүний нэр, төрөл ч олширсоор байна. Зөвхөн уул уурхайн тоног, төхөөрөмж гэлтгүй эмийн бүтээгдэхүүн, эмчилгээ, тээвэрлэлтийн тоног төхөөрөмж, төмөрлөг, хувцас гэх мэт бараа бүтээгдэхүүн зонхилж. Өнгөрсөн жилийг эргэн харахад хоёр улсын харилцаа уул уурхай, арилжааны талбараас аль хэдийнэ хальсан байна. Тухайлбал, Монголын зэвсэгт хүчин болон энхийг сахиулах үйл ажиллагааг бэхжүүлэх, чадамжийг дээшлүүлэхэд хамтарч байна. Түүнчлэн Монгол нөхөдтэйгээ гар нийлэн төрийн үйлчилгээний шинэлчлэл дээр ажиллаж байгаа. Энэ нь цаашдын харилцаа, хамтын ажиллагаа илүү эрүүл, урт хугацаанд тогтвортой, хүчирхэг байх нөхцөл

бүрдүүлж байгаа юм.

**-Монголын одоогийн улс төр, бизнесийн орчныг хэрхэн дүгнэж байна вэ?**

-Дэлхийн олон оронд амьдарч, ажиллаж байсаны хувьд нэг зүйл тодорхой санагддаг. Ази, Америк болон Европын орнуудын хувьд улс төр, худалдааны харилцаа нягт уялдаатай байдаг учир нэгийнх нь эдийн засаг доройтоход бусад нь хэвийн үлдэж чаддаггүй.

Монголд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, сонгуулийн эргэн тойрон дахь үйл явдал, сонгуулийн дараах Оюутолгойн гэрээний асуудал зэрэг хэд, хэдэн хүчин зүйлийг өнгөрсөн хугацаанд харлаа. Одоо Ашигт малтмалын тухай хууль гараад ирчихлээ. Миний зүгээс тэднийг сайн, муу гэж дүгнэж байгаа юм биш. Гагцхүү хөрөнгө оруулагчдад олон тодорхойгүй нөхцөл үүсгэсээр байгаа нь үнэн. Энэ нь улмаар бизнес эрхлэх хүсэл зоригт сөргөөр нөлөөлж байна.

**-Элчин сайдын хувьд Та Монголыг Канад улсын ямар туршлагаас суралцаасай гэж боддог вэ?**

Тогтвортой байдал, бизнесийн итгэл даах чадвар. Канад улс Монгол шиг газрын баялгаа ашиглах замаар эдийн засгаа босгож ирсэн. Эдийн засгийн хувьсгал бий болгох замналдаа олон алдаа гаргасан ч түүнээсээ суралцахыг мөн давтахгүйг хичээж байв. Монгол Улстай дээрх туршлагаа хуваалцаж чадна гэдэгт итгэж байна. Мөн газар нутгийн хэмжээ, хүн ам, газар зүй, цаг агаарын нөхцөл гээд Монголтой ижил төстэй чанар олон тул бидний зүгээс хуваалцах туршлага чамгүй бий. Манай хоёр орны аль, аль нь байгалийн баялаг ихтэй. Бид гараа нэгтэй орнууд. Ийм шийдвэр гаргаагүй бол гэж бидний нэхэн харамсаж буй алдаатай зарим шийдвэрээс өнөөгийн Монголын бодлого тодорхойлогчид хэрхэн зайлсхийх тал дээр хуваалцах сургамж бий.

**-Ази тивд чиглэсэн Канад улсын бодлого, сонирхол хаана төвлөрч байна вэ?**

-Ази тивийн өсөн нэмэгдэж буй үүрэг, оролцоог мэдэрч ажиллах тал дээр барууны зарим оронтой харьцуулахад бидний хувьд харьцангуй хойрго, хоцрогдонгүй яваа нь үнэн. Гэвч манай улсын Ерөнхий сайд энэ талаар маш тодорхой мэдэгдэл хийсэн. Тэрбээр Канад улс нь дэлхийн эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр Ази тив рүү жолоогоо залах нь нэн чухал агаад, зайлж болшгүй зам гэсэн. Тиймээс ч бидний хувьд эдийн засаг, улс төрийн холбоотноо энэ зүгт төрөлжүүлэх үүднээс Зүүн өмнөд Азийн үндэстнүүдийн холбоо, Өмнөд Солонгос тэргүүтэй Ази тивийн улсуудад хөрөнгө илүү ихээр оруулах бодлогыг барьж байна. Бид гараанаас хоцорч гарсан ч эрчтэй урагшилж байгаа.

**-Монгол Улс төсвийн чанга бодлого хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллаж буй ч багагүй сорилтуудтай тулгарч буй. Канад улсын хувьд дээрх асуудлыг Төсвийн тогтворжуулалтын сан эсвэл өөр ямар арга механизмаар зохицуулдаг вэ?**

-Энэ талаас харвал Канадад дэлхийн санхүүгийн хямрал хэзээ ч болж байгаагүй гэж хэлнэ. Бусад улс тэр дундаа Америкийн санхүүгийн эрсдэлийн олон тооцоолол бүхий системийг Канадын банк, санхүүгийн зохицуулалт хүлээн зөвшөөрдөггүй. Өөрөөр хэлбэл, бидний хувьд банкуудыг эрсдэлд оруулж болох бүтээгдэхүүн, талбарт санхүүгийн байгууллагуудаа хөрөнгө оруулахыг зөвшөөрдөггүй. Бусад улсын эдийн засагт ажиглагдаж байсан хямралын үе шат гэж манайд байгаагүй. Өнгөрсөн хямралын үеэр ажилгүйдлийн түвшин өссөн ч тухайлбал, Америктай харьцуулахад доогуур байлаа. Орон сууцны үнэ ч тогтвортой байсан. Бид дэлхийн санхүүгийн хямралын он жилүүдийг ажралгүй давсан.

Хямралыг мэдрэлгүй өнгөрөхөд нөлөөлсөн бас нэг томоохон хүчин зүйл нь манай улсын төсөв, сангийн чанд хатуу, зарчимч бодлого байв. Санхүүгийн хямрал болохын өмнөх 8-10 жилийн хугацаанд Канад

► улсын төсөв байнгын илүүдэлтэй явж ирсэн. Энэ нь ч хямралын үед бидэнд тодорхой хэмжээнд зөөлөвч болсон. Өнөөдрийн байдлаар Засгийн газар төсвийн зарлагаа хянаж, сангийн бодлогоо чангатгаж, эерэг тэнцэлд барих үүднээс Төсвийн алдагдал танах хөтөлбөрийг (DRAP) хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Энэ бол бидний зорилго. Тогтворжуулалтын сан манайд байдаггүй. Бороотой өдөрт зориулсан

-Канад улс өнгөрсөн 30 жилийн хугацаанд хоёр чухал хичээлийг маш сайн заалгасан. Нэгдүгээрт, Чөлөөт худалдаа үр өгөөжөө өгдөг. Хоёрдугаарт, глобальчлагдсан өнөө үед эдийн засгаа ханаар хаших нь ялалтын зам биш.

**-Канадчуудын сонирхлыг Монголын ямар боломжууд татаж байна вэ?**

-Уул уурхай одоохондоо давамгайлсан шинжтэй байгаа ч

байна. Энд үйл ажиллагаа явуулдаг Канадын компаниуд ажилчдаа өөрийн сургалтын хөтөлбөрөөр сургадаг. Харин одоо Канадын боловсролын байгууллагууд Монголд ирж, энэ салбарт түншлэх сонирхолтой байна. Жишээлбэл, Канадын "British Columbia" их сургууль, Монголын ШУТИС-тай хамтран уул уурхайн инженер болон бусад мэргэжлээр сургалтын хөтөлбөр, материал болон окутан солилцох гэрээ байгуулаад байна.

Бидний зүгээс Канадын боловсролын байгууллагуудыг оролцуулж Монголд боловсролын үзэсгэлэн зохион байгуулна гэж бодож байна.

**-Монголд үйл ажиллагаа явуулахад Канадын компаниудад нийтлэг ямар бэрхшээл тулгарч байна вэ?**

-Монголд жил бүр ирдэг Канад хүмүүсийн тоо чамлахааргүй ч хурдацтай өсч байна. Статистикаас үзэхэд өнгөрсөн жил нийт 3700 канад хүн ирсэн байгаа юм. Энэ бол өмнөх жилтэй харьцуулахад 50 хувиар өссөн үзүүлэлт.

Тулгарч буй саад гэвэл нэн тэргүүнд ойлголтын асуудал байна. Канадчуудын хувьд Монгол хурдацтай хөгжиж буй орон гэдэг талаас нь анхаарлаа хараахан хандуулж эхлээгүй. Канадчуудын ойлголтод төв Азид оршдог Монгол хэмээх нэртэй оронд сонирхол татам үйл явц өрнөж эхэлж байгааг ойлгож эхэлж

буй дүр зураг л харагдаж буй.

Канадад байхдаа би хүмүүст Монгол орон гэж хаана байдгийг газрын зураг дээр үзүүлэх хэрэг гардаг байсан ч өнөөдөр тэгэх шаардлагагүй болжээ. Тэд миний тусламжгүйгээр Монголыг газрын зургаас олж чаддаг болж. Бид хууль эрх зүйн урьдчилан хэлж болохуйц тогтвортой орчныг бүрдүүлэхэд урт удаан зам туулах биз ээ. Гэсэн ч дэлхийн өнцөг булан бүрт оршин суугаа бизнес эрхлэгчдийн Монгол хэмээх амжилтын түүхийн нэг хэсэг байх хүслийг хууль, эрх зүйн тогтвортой орчин л төрүүлдэг. ■



нөөц байхгүй ч төсвийн хяналтыг чангатгаж, тэнцвэртэй байдлыг удаан хугацаанд хангаж чадсанаар нэг талаас үр ашгийн дээд хязгаарт нөгөө талаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний зардал доод хязгаарт хүрэх учиртай. Энэ бол бороотой өдөр гар дүрдэг нөөц сантай адилгүй. Харин хямралын үед болон хямралын дараа ч үргэлжилж байдаг сангийн хумих бодлогын үйл явц юм.

**-Канад улсын орчин үеийн түүхэнд жинтэй хувь нэмэр оруулсан ололт, амжилтуудаас хуваалцахгүй юу?**

төрөлжиж эхэлж байна. Ойрын үед Канадын компаниуд эрүүл мэнд, боловсролын салбарыг ихээхэн сонирхож буй нь илт байна. Саяхан л гэхэд агаарын бохирдол, жирэмсний үеийн асаргаа гэх мэт асуудалд зөвлөгөө өгөх зорилготой эрүүл мэндийн томоохон судалгааг Монголд хийх санхүүжилтийг Канадын тал хариуцаж байгааг мэдлээ. Мөн бид боловсролын байгууллагуудад сургалтын хөтөлбөрөө танилцуулах, Монголын багш нартай туршлага хуваалцан хамтрахаар түншлэлийн түвшинд явж

ХӨРШҮҮД

# УЛАМ ХҮЧИРХЭГЖИНЭ


## Б.ҮҮРИЙНТУЯА

Урд хөршийнхөн батлан хамгаалахын салбартаа харамгүй хөрөнгө оруулалт хийхээр төсөвлөжээ. Эдийн засаг нь удаашраад буй энэ үед цэргийн үйл ажиллагаандаа анхаарах нь зүйтэй гэж тус улсын шинэ удирдагч үзсэн бололтой хэмээн шинжээчид дүгнэж байна.

Хуучин удирдагч Вэнь Зябаог Хятадын Ерөнхий сайдын үүрэгт томилох үед уг төсвийн төслийг өргөн барьжээ.

Их Британи энэ чиглэлд жилд дунджаар 34 тэрбум, Энэтхэг 25 тэрбум фунт стерлинг зарцуулдаг. Хятадын Засгийн газар батлан хамгаалахын салбартаа 720 тэрбум юань буюу 75 тэрбум фунт стерлинг төсөвлөсөн нь өмнөх онтой харьцуулахад 10.7 хувиар өссөн үзүүлэлт аж. Түүнчлэн ирэх жилүүдэд уг төсвийг газар нутгийн маргааны өрсөлдөгч болох Япон улсаас гурав дахин нэмэгдүүлэх зорилт тавин ажиллах тухайгаа Хятадын Засгийн газраас мэдэгджээ. Хэдийгээр урд хөршийн эрх баригчид батлан хамгаалахын салбарын төсвийг жил бүр ахиулж ирсэн ч АНУ-ын хэмжээнд хүрэх болоогүй юм. Дэлхийн хамгийн хүчирхэг орон гэгдэх АНУ жилд дунджаар 470 тэрбум фунт стерлингийг тус салбарт зарцуулдаг байна.

Эдийн засгийн хөрөлт, ДНБ-ий өсөлт нь 7.5 хувьтай байна гэх таамгийн эзэн болсон Хятад ийнхүү үрэлгэн хандаж байгаа, тус улсын удирдагч Ши Жинпинг цэрэг, армийн



үйл ажиллагаатай танилцахад “зав” их гаргах болсон нь дэлхийн анхаарлын “дуранд” өртөх шалтгаан болж буй. Тэрбээр “Хятад үндэстний сүр, хүчийг сэргээхийн тулд баян улс бүтээхийн зэрэгцээ зэвсэгт хүчнийг хөгжүүлэх нь чухал” гэжээ. Хятадын энэ бодлогыг шүүмжлэх улс олон ч тус улсын удирдагчид “Хятад улс батлан хамгаалахын салбараа хүчирхэгжүүлэх бодлогыг дэмжиж буй нь дайн өдөөх зорилго агуулаагүй” гэдгийг онцолж байгаа юм. Ийнхүү тус улсын Үндэсний Конгрессийн 3000 гишүүн төсвийн төсөлд тамгаа дарахад бэлэн байгаа ажээ.

Нанжины цэргийн хүчний генерал Синг Вейжанг “Манай улс цэргийн хүчинд чамгүй мөнгө зарцуулж буйгаа дэлхий нийтэд тайлбарлах ёстой мэт хандлага гаарсаар байна. Засгийн газрын энэхүү бодлого нь дотоодын аюулгүй байдлаа бататгах, дэлхийн энхийг сахиулах үйлсэд бидний зүгээс оруулах хувь нэмрийн өчүүхэн хэсэг юм” хэмээн BBC агенттаг өгсөн ярилцлагадаа онцолжээ. Мөн

тэрбээр “Батлан хамгаалах салбар үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой” гэв. Харин АНУ-ын Тэнгисийн цэргийн коллежийн багш Андро Эриксон “Хятадын батлан хамгаалах салбарын төсөв ийнхүү өсөж буй нь санаа зовинох асуудал биш. Учир нь төсвийн хэмжээг тус улсын инфляцитай харьцуулж үзвэл ердөө 3.1 хувийн жилийн дундаж өсөлт гарч байгаа юм” хэмээн өөрийн цахим хуудастаа өгүүлжээ. Өнгөрсөн таван жилийн тайландаа Хятадын удирдагч асан Вэнь Зябао “Хятадын эдийн засгийн өсөлт хоёр дахин нэмэгдэж 5.5 их наяд фунт стерлингэд хүрсэн төдийгүй дэлхийн санхүүгийн хямралыг ажрахгүй туулж байна” хэмээн тэмдэглэсэн удаатай. Тэрбээр “Таван жилийн төлөвлөгөөт ажлын хүрээнд нисэх онгоцны буудал 31, 18 сая айлын орон сууц болоод 19300 гаруй километр хатуу хучилттай зам нэмж байгуулсан. Эдгээр амжилтын өгөөж Хятад үндэстний амьдралд эерэгээр нөлөөлсөөр байх болно” гэжээ. ■

# УГОГҮЙ ОРОС



хүний нутагт нэлээн зүдрэх болно” гэв. Товчхондоо Венесуэльд оруулах хойд ахан дүүсийн хөрөнгө оруулалт хумигдах юм.

Уго Чавес ОХУ-тай улс төр, бизнесийн харилцаагаа өргөжүүлэхийг хүсдэг байсан. Өнгөрсөн жилүүдэд Венесуэль нь Оросын Өмнөд Америк дахь стратегийн хамгийн том түнш болж чадсан бөгөөд дийлэнх төсөл нь газрын тосны салбарт хэрэгждэг аж. Хамгийн том хөрөнгө оруулалт нь Ориноко сав газарт хэрэгжиж буй “Junin-6” төсөл аж. Уг төслийн нийт хөрөнгө оруулалтыг 20 тэрбум ам.доллараар үнэлж байгаа юм. Түүнчлэн ОХУ-ын газрын тосны магнат “Роснефть” компани тус улсад газрын тос олборлох таван төсөл эхлүүлээд байна. Шинжээчдийн хэлснээр дээрх төслүүд улс төрийн шуурганд хамгийн түрүүнд өртөх магадлалтай аж. Харин “Роснефть” компанийн захирал Игор Сечин “Төслүүдийн гэрээг үзэглэсэн. Манай улсаас тус улсад оруулах хөрөнгө оруулалт, хэрэгжих төслүүдэд ямар ч саад тулгарахгүй” хэмээн онцолжээ.

Дээрх хоёр улсын батлан хамгаалахын салбар дахь хамтын ажиллагаа хэрхэн үргэлжлэх нь олны анхаарлыг ихээхэн татаж байгаа. Учир нь, Венесуэль улс нь ОХУ-ын зэвсгийн экспортын зах зээлийн хоёр дахь том худалдан авагч юм. ■

**В**енесуэлийн Ерөнхийлөгч Уго Чавес таалал төгссөн нь гэнэтийн бус ч цочирдуулам мэдээ байлаа. Эл үйл явдал тус улсад үйл ажиллагаа эрхэлдэг ОХУ-ын компаниудад сөрөг үр дагавар даллаж болохыг олон улсын шинжээчид хэлж байгаа юм.

Уго Чавесын халааг авах хүнээр Венесуэлийн Дэд ерөнхийлөгч Николас Мадурог тодруулаад буй. Гэвч улс төрийн тодорхойгүй байдал тус улсын төдийгүй олон улсын хамтын ажиллагааг хааш нь хөтлөхийг таах аргагүй байгаа аж. ОХУ-ын Шинжлэх ухааны академийн ажилтан Владимир Сударев “Николас Мадуро төрийн эрхэнд гарлаа гээд онцын өөрчлөлт гарахгүй л болов уу. Учир нь, тэр Уго Чавесын адил зүүний талын хүн” гэсэн бол ОХУ-ын Үндэсний эрчим хүчний институтын ерөнхий захирал Сергей Правосудов нэгэн ярилцлагадаа “Ирээдүй хаашаа эргэхийг урьдчилан харах аргагүй. Венесуэльд сууршилтай Оросын компаниуд ямар ч үед тодорхой хэмжээгээр өөрчлөлтийг

давах шаардлага тулгарна. Гол нь хэр хэмжээний хохирол амсах вэ гэдэг эрсдэлийг л сайтар тооцох хэрэгтэй” хэмээжээ. Шинжээчдийн дүгнэж буйгаар Венесуэльд үйл ажиллагаа эрхэлж буй хойд хөршийн компаниудын хэтийг тодорхойлоход бэрхийн зэрэгцээ Венесуэлийн талаас гэрээ, хэлэлцээрийг хэрхэн үргэлжлүүлэх нь бүрхэг байгаа аж.

Хойд хөршийн Үндэсний эрчим хүчний сангийн дарга Константин Симонов “АНУ-ын хөрөнгө оруулагчдыг Уго Чавесын үед “хөөсний” адилаар ОХУ-ын бизнесмэнүүдийг улсаасаа гаргах болно. Ингэсэн тохиолдолд тус улсад хөрөнгө оруулахын тулд Засгийн газраас нь олгодог байсан татаас болон бусад боломжоос хагацах юм” гэсэн байна. Түүний энэ таамгийн талаар ОХУ-ын Шинжлэх ухааны академын харьяа Латин-Америк судлалын төвийн гүйцэтгэх захирал Владимир Сурадев “Шууд хөөхгүй байх гэж найдаж байна. Гэхдээ тэдний үйл ажиллагааг хязгаарлах болов уу. Эцэст нь Угогүй хоцорсон Оросын хөрөнгө оруулагчид

## ЭДИЙН ЗАСАГЧИЙН БУЛАН

# ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРТ ХӨГЖЛИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГО ҮГҮЙЛЭГДЭЖ БАЙНА

Ч.ЭНХБОЛД /СЭЗДС-ИЙН БИЗНЕСИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМИЙН АНХЛАХ БАГШ, PhD/

*...XX зууны сүүлийн хагас гэхэд аж үйлдвэрийн салбар дахь техник технологийн дэвшил нь бүхий л төрлийн биет бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргах боломжийг бий болгож, бүтээмжийг ихээхэн дээшлүүлжээ...*

Эдийн засгийн салбар болон өрсөлдөөний стратеги судлаач Майкл Портер “Өрсөлдөөний стратеги” номдоо (Competitive strategy, 1980) “Эдийн засгийн салбар гэдэг нь өөр хоорондоо ижил төстэй эсвэл орлох түүхий эд олборлож, бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг бизнес эрхлэгчид болон компаниудын цогц” гэжээ. Өнөөдөр бидний хэлж ярьж, ойлгож заншсан энэхүү эдийн засгийн салбар хэмээх ойлголт түүхэн цаг хугацааны явцад өөрчлөгдөн хувьсаж, нөхцөл байдлыг даган шинэ ойлголт ухагдахуунаар улам бүр баяжиж ирсэн байдаг.


Эдийн засагч Адам Смитийн (1723-1790) үед эдийн засгийн гол үйл ажиллагаа нь ихэвчлэн мал аж ахуй болон газар тариалан, гар урлалд тулгуурласан байжээ. Аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнд 1800 оны эхний хагаст гарсан техник технологийн нээлтүүд үйлдвэрийн салбарын хөгжлийг хурдасгасан байна. XX зууны сүүлийн хагас гэхэд аж үйлдвэрийн салбар дахь техник технологийн дэвшил нь бүхий л төрлийн биет бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргах боломжийг бий болгож, бүтээмжийг ихээхэн дээшлүүлжээ. Мөн яг энэ цаг үетэй давхцан хөгжингүй орнуудын ДНБ-ий талаас илүү хувь нь үйлчилгээний салбараас

бүрдэх болсон байна. Энэхүү салбарын бүтцийн өөрчлөлтийг бид олон баримт жишээнээс харж болно. Заримаас нь дурдвал:


-1995 оны байдлаар Дэлхийн банкны өгөгдөл дээр тулгуурласан бага болон өндөр орлоготой улсын хувьд ДНБ-д үйлчилгээний салбарын эзэлж буй хувь хэмжээг /Зураг 1/-д харууллаа. Уг графикаас харвал өндөр орлоготой улсад үйлчилгээний салбарын эзлэх хувь 66 хувиас дээш байсан бөгөөд бага орлоготой улсын хувьд 38 хувийн доогуур байжээ.

Салбарын бүтцийн хувьд нэг хүнд оногдох орлогын хэмжээ өсөх тусам нийт ажил эрхлэлтэд үйлчилгээний салбарын эзлэх хувь өсдөг байна. Энэхүү хандлага дэлхийн түвшинд ямар байгааг /Зураг 3/ харж болно. Судлаач Luis Rubalcaba-Bermejo “Шинээр хөгжиж буй үйлчилгээний эдийн засаг” (The new service economy, 2007) номдоо 2004 оны байдлаар Европын холбооны 15 улсын нийт ажиллах хүчний 70 хувиас дээш хувийг үйлчилгээтэй холбоотой эдийн засгийн салбаруудад ажиллаж буй хүмүүс бүрдүүлж буйг OECD болон Eurostat – н тоон баримтад тулгуурлан гаргасан байна.

Дэлхийн хэмжээний том компаниудын чансааг эрэмбэлж жагсаадаг 1955 оноос гарч эхэлсэн “Fortune 500”, 2003 оноос гарсан



Зураг 1.




► “Forbes Global 2000” жагсаалтын ихээхэн хувийг үйлчилгээний салбарт ажиллаж буй компаниуд эзэлж байна. Тухайлан авч үзвэл, “Forbes Global 2000” нь дэлхийн хэмжээний томоохон компаниудын борлуулалт, ашиг, хөрөнгө, зах зээлийн үнэ цэнэ гэсэн дөрвөн үзүүлэлтээр жагсаалтыг гаргадаг.

2003 оны байдлаар “Fortune 500” жагсаалтын 23.1 хувийг Азийн үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд эзэлж, Азид

аж үйлдвэрийн салбар давамгайлж байгаа боловч үйлчилгээний салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд оруулах хувь нэмэгдэж буйг Peter W. Danielsis, Tom Huttonis, Ho Kong Chongis нар судлан тогтоожээ.

Энэхүү салбарын бүтцийн өөрчлөлт Монгол Улсын хувьд зайлшгүй ирэх ирээдүйн чиг хандлага учраас бид үйлчилгээний салбарын хөгжлийн зөв зохистой бодлогыг эртнээс үр ашигтайгаар тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна. ■



## БОДЛОГЫН СУДАЛГАА

ЭДИЙН ЗАСАГТ ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

ГАЛИНДЭВИЙН РАГЧААСҮРЭН /“ГЭРЭГЭ ПАРТНЕРС” ХХК,  
QUEEN'S UNIVERSITY BELFAST/

*...Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн /ERI/-гээс хэрэгжиж буй “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн эдийн засагт үзүүлэх нөлөө” судалгааны товч дүгнэлтийг хүргэж байна. Энэхүү судалгааг ИБУИНВУ-ын Велфаст хотын Хатан хааны их сургуулийн эдийн засгийн профессор Г.Рагчаасүрэн боловсруулжээ...*

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлтөөс болж 2005-2008 оны хооронд манай улсын төсвийн орлого, зарлага эрс нэмэгдсэн. Тухайлбал, 2005-2006 онд нэг тонн зэсийн үнэ 3675-6731 ам.доллар хүртэл өссөн бол алтны үнэ 26 хувиар нэмэгдсэн. Үр дүнд нь Засгийн газрын нэрлэсэн орлого (буцалтгүй тусламж, шилжүүлгийг оруулалгүйгээр) 2005-2006 онд 62 хувиар, 2006-2007 онд 37 хувиар, 2007-2008 онд 15 хувиар тус тус нэмэгдсэн (эх сурвалж: ҮСХ). Төсвийн тэнцлийн нөгөө талд Засгийн газрын зардал 2005-2006 онд 61 хувиар, дараагийн хоёр жилд 40 орчим хувиар тус тус нэмэгджээ (эх сурвалж: ҮСХ).

Түүхий эдийн үнэ өндөр байсан дээрх жилүүдэд, Монгол Улсын бодит ДНБ жил бүр дунджаар 10 хувиар өссөн. 2008 оны санхүүгийн хямрал манай эдийн засагт хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн. Учир нь нэг тонн зэсийн үнэ 2008-2009 онд 7000-5100 ам.доллар болтлоо огцом унасан нь 2009 онд эдийн засаг 1.6 хувиар агших үндсэн шалтгаан болсон. Үүн дээр Засгийн газрын нэрлэсэн зардал 5.7 хувиар буурсан нь хямралын сөрөг нөлөөг улам нэмэгдүүлсэн. Дээрх тоо баримтуудыг харахад Засгийн газрын орлого ба зардлын хоорондох хамаарал эерэг байсан

гэж дүгнэж болох юм. Үүнээс гадна 2006 онд инфляцийн түвшин 6.8 хувь, 2007 онд 17.8 хувь, 2008 онд 22 хувь, 2009 онд 4.4 хувь тус тус байсан нь үүнтэй холбоотой юм. Гадаад шокийг улам дэвэргэсэн макро эдийн засгийн мөчлөг дагасан бодлого нь манай орны хувьд ялангуяа уул уурхайгаас улам бүр хамааралтай болж буй өнөөгийн нөхцөлд тохиромжгүй гэдгийг монголчууд бид эндээс сургамж болгон авсан.

Эдийн засагчид болон улс төрчид эдийн засаг өсөлттэй байх үед тэр хэмжээгээр зарцуулахын оронд хадгаламжаа нэмэгдүүлснээр хямралын үед Засгийн газрын зардлыг нэмэгдүүлэх замаар эдийн засгаа тогтвортой авч үлдэх хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлж байв. Өөрөөр хэлбэл, мөчлөг сөрсөн бодлого барих нь зүйтэй гэдэг байр суурьтай болсон. УИХ-аас 2011 онд баталсан Төсвийн тогтвортой байдал (ТТБ)-ын тухай хуулинд Засгийн газрын зардлын өсөлтийн хувийг тогтвортой байлгах заалтыг тодорхой тусгасан. 2013 оны төсвийг УИХ уг хуулийг үндэслэн баталсан.

Энэхүү судалгаанд бид ТТБ-ын тухай хуулийн Монгол Улсын эдийн засагт үзүүлэх нөлөөг судлах зорилгоор динамик, жижиг нээлттэй эдийн засгийн Тооцоолж болох ерөнхий тэнцвэрийн (Comput-

able General Equilibrium буюу CGE) загварыг боловсруулсан. Уг загвар нь 2005 онд хийгдсэн Монгол Улсын Салбар хоорондын тэнцэл (СХТ) дээр суурилсан. Жижиг нээлттэй эдийн засгийн загвар болохын хувьд бүх бүтээгдэхүүн үйчилгээний дэлхийн зах зээл дээрх үнийг эгзэген буюу гаднаас шууд оруулж өгдөг. Динамик загвар болохын хувьд капитал болон гадаад өр нь цаг хугацааны хувьд хувьсан өөрчлөгдөж байдаг. Энэ утгаараа уг загвар нь Солоугийн загварын олон салбартай, нээлттэй эдийн засгийн өргөтгөл юм. Уг загвар нь хугацаа бүрийн хувьд доорх тэгшитгэлүүдийг агуулж байдаг:

- Бүтээгдэхүүн үйлчилгээ бүр дээр үүсэх өрхийн эрэлт
- Бүтээгдэхүүн үйлчилгээ бүр дээр үүсэх хөрөнгө оруулагчийн эрэлт
- Бүтээгдэхүүн үйлчилгээ бүр дээр үүсэх Засгийн газрын эрэлт
- Бүтээгдэхүүн үйлчилгээ бүр дээр үүсэх экспортын эрэлт
- Бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хүчин зүйл бүр дээр үүсэх үйлдвэрлэгчдийн эрэлт
- Бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хүчин зүйл тус бүрийн нийлүүлэлт
- Үйлдвэрлэлийн өртөг болон худалдан авагчдын үнэ
- Хэвийн ашгийн нөхцөл ба бүтээгдэхүүний гарц
- Зарим эгзэген хувьсагчийн динамик өөрчлөлт
- Бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хүчин зүйл бүрийн зах зээлийн тэнцвэр
- ДНБ, ҮНБ, төлбөрийн баланс, үнийн индекс гэх мэт макро эдийн засгийн үзүүлэлтүүд.

Зохиогч МУИС-ийн Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)-д уг судалгааг хийх санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд талархаж байна. Энэ судалгааны ажил нь бүрэн дуусаагүй байгаа бөгөөд энд танилцуулсан үр дүнгүүд урьдчилсан байдлаар байгаа гэдгийг анхаарна уу.



Фотог Ү.ОДБАЯР

► Үйлдвэрлэгчид болон эцсийн хэрэглэгчид (өрх, Засгийн газар, хөрөнгө оруулагч, экспортлогч)-ийн хооронд, бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хүчин зүйлс (хөдөлмөр, капитал, байгалийн баялаг, газар)-ийн зах зээл дээр үүсэх гүйлгээ нь ашиг болон ханамжийг хамгийн их байлгах сонголт дээр үндэслэдэг.

2005 оны СХТ нь 55 салбартай. Бид үүнийг дараах томоохон салбарууд руу нэгтгэж судалгаандаа ашигласан. Үүнд: мал аж ахуй, газар тариалан, загас болон ойн аж ахуй, байгалийн хий болон газрын тос, нүүрс (эрчим хүчний, коксжих, угаасан), зэс (Оюу Толгойн ба бусад), алт (Оюу Толгойн ба бусад), эрдэс баялаг (Оюу Толгойн ба бусад), түлш шатахуун, эрчим хүч, боловсруулах аж үйлдвэр, тээвэр, барилга, эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргаа ба батлан хамгаалал, үйлчилгээ орсон.

ТТБ-ын тухай хуулийн эдийн засагт үзүүлэх нөлөөг судлахын тулд бидэнд 2012 оны байдлаарх СХТ шаардагдана. Үүнийг гаргахын тулд бид загвараа 2005-2012 оны хооронд ажиллуулж Монгол Улсын эдийн засгийн ерөнхий төлөв байдлыг харуулж байхаар параметр утгуудыг сонгосон. Ингэхдээ 2005-2012 оны хооронд ажиглагдсан зарим үзүүлэлтүүдийг онилсон. Үүнд: ДНБ-ий өсөлт; ДНБ-ий дундаж дефлятор, хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, Засгийн газрын зардал, цэвэр экспорт, зарим салбарын нийт гарцын дундаж өсөлт болон тэдгээрийн үнийн индексийн дундаж өөрчлөлт орсон. Зарим хувьсагчид бодит байдал дээр ажиглагдсан утгаасаа их зөрөх тохиолдол гарсан нь загварыг улам боловсронгуй болгох шаардлагатай болохыг харуулж байгаа. Энэ нь бол бидний цаашдын судалгааны анхаарах зүйл мөн.

ТТБ-ын тухай хуулийн гол зорилго нь Засгийн газрын нийт зардлын өсөлтийг тогтворжуулахад оршдог. Засгийн газар илүү гарсан аливаа орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд (ТТС) хадгалсанаар улсын хадгаламжид дэмжлэг болох боломжтой. Уг сан нь хамгийн багадаа ДНБ-ий ►

*СХТ нь Нийгмийн бүртгэлийн матрицад багтдаг зарим ажил гүйлгээг тусгадаггүй учир зарим ажил гүйлгээг төдийлөн харуулдаггүй. Жишээлбэл, өрхийн орлого болох хөдөлмөрийн хөлс, капиталын орлого, шилжүүлэг гэх мэтийг нарийн ялгаж харуулаагүй учраас, бид загвартаа тодорхой нөхцөл тавих шаардлагатай болсон.*

*Худалдан авагч бүр бүтээгдэхүүн бүрийн оновчтой хэмжээг сонгохдоо дотоодоос болон импортоор гэсэн эх үүсвэрээр нь задалдаг. Бид өрх болон Засгийн газрын хувьд Кобб-Дугласын ханамжийн функцийг, үйлдвэрлэгчидийн хувьд Леонтивийн үйлдвэрлэлийн функцийг авч үзсэн. Мөн дотоодоос болон импортоор авах сонголтын хувьд Орлуулалтын тогтмол мэдрэмжтэй функцийг авч үзсэн.*

» таван хувьтай дүйцэхүйц хуримтлалтай байх бөгөөд 10 хувиас давсан тохиолдолд инфляци зэрэг тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан Хөгжлийн банк болон Хүний хөгжлийн сангаар дамжуулан эдийн засаг руу хөрөнгө оруулалт хийх боломжтой. Энэ судалгаанд бид 2013-2015 оныг авч үзэж байгаа боловч энэхүү нийтлэлд зөвхөн 2013 оны байдлаарх үр дүнг харууллаа.

Дээр дурдсанчлан 2013 оны төсвийг УИХ ТТБ-ын тухай хууль дээр үндэслэн баталсны дагуу Засгийн газрын нийт зардлыг 2013 оны нэрлэсэн дүнгээрээ 18 хувиар нэмэгдүүлэхээр тогтсон. Бидний загвар нь Нийгмийн бүртгэлийн матриц (SAM) дээр суурилагүй учраас Засгийн газрын нийт орлого, зарлагын хэмжээг тооцдоггүй. Харин СХТ-д байгаа Засгийн газрын цэвэр татварын орлого болон бүтээгдэхүүн үйлчилгээний худалдан авалт дээр үндэслэдэг. Иймд бид Засгийн газрын бүтээгдэхүүн үйлчилгээний худалдан авалт 2013 оны төсөвт заасан нийт зардлын өсөлттэй адил буюу 18 хувиар өснө гэсэн нөхцөлтэйгээр уг загварыг дөрвөн хувилбараар симуляци хийлээ. Эхний буюу үндсэн хувилбарт, уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ 2013 онд өмнөх оныхоос нэлээд доогуур байна гэсэн Засгийн газрын хүлээлтийг баримталсан. Тухайлбал, Энэ онд нэг тонн коксжих нүүрсний үнэ 80 ам.доллар, нэг тонн зэсийн үнэ 6329 ам.доллар болно гэж үзүүлсэн.

Хоёр дахь хувилбарт, зөвхөн зэс ба коксжих нүүрсний үнэ 2012 оны түвшинтэй ижил буюу 106 ам.доллар, 7471 ам.доллар болно гээд бусад талаараа үндсэн хувилбартай адил гэж үзсэн. Гурав дахь хувилбарт, зэс болон коксжих нүүрсний үнэ үндсэн хувилбарт байгаагаас 10 хувиар буурах тохиолдлын нөлөөг судалсан. Дөрөв дэх буюу эцсийн хувилбарт, хэрэв тус хууль огт хэрэгжээгүй бол гэсэн тохиолдлыг судалж үндсэн хувилбартай харьцуулсан. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын нэрлэсэн зардал 2005-2011 оны дундаж болох 26.7 хувиар өсөж харин бусад бүх нөхцөлүүд үндсэн хувилбарт байгаагаар адил байна гэж үзсэн.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд (%)	Хувилбар нэг	Хувилбар хоёр	Хувилбар гурав	Хувилбар дөрөв
Бодит экспорт	38.07	38.78	39.35	37.71
Бодит ДНБ	23.59	23.65	23.23	23.60
Бодит импорт	19.19	19.53	17.97	19.84
Татварын нэрлэсэн орлого	25.50	27.13	26.03	25.75
Тээвэр	24.49	25.02	23.8	24.07
ДНБ-ий дефлятор	5.85	8.97	3.81	7.01
Уул уурхайн салбарын гарц	44.30	44.64	43.93	44.30
Бусад салбарын гарц	11.26	11.17	11.61	11.63
Улсын нэрлэсэн хадгаламж	34.97	42.72	29.82	34.88
Бодит цалин	12.34	12.44	9.98	14.28

Энэ арга нь судалгааны салбарт түгээмэл байдаг. Учир нь CGE загварын параметруудийг үнэлэх уламжлалт арга нь хэд хэдэн асуудал тулгардаг. Үүний нэг нь, ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд, мэдээ мэдээллийн хомс байдал юм. Үнэлэх параметруудийн тоо олон учир хувьсагчдын урт хугацааны цуваа мэдээлэл шаардлагатай болдог. Гэхдээ

Макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн өсөлтийг дөрвөн хувилбараар гаргаж харьцуулсаныг дээрх хүснэгтэд үзүүлэв. Эндээс харахад ДНБ-ий дефлятор, бодит цалин ба улсын нэрлэсэн хадгаламж нэлээд ихээр хувьсаж байхад бодит ДНБ-ий өсөлт, бодит экспортын өсөлт, уул уурхайн болон бусад салбарын өсөлт маш тогтвортой байхаар байна. Үүний шалтгаан нь Засгийн газрын зардлын тогтвортой өсөлт эдийн засгийг гадаад үнийн нөлөөнөөс хамгаалж байгаагийн үр дүн юм. Эхний болон сүүлийн хувилбаруудыг харьцуулахад, ТТБ-ын тухай хуульгүй байсан бол инфляци илүү өндөр, бодит экспорт буурах, бодит импорт өсөх хандлагатай байна. Үүний учир нь, манай бүтээгдэхүүн ерөнхийдөө дэлхийн зах зээл дээр илүү үнэтэй болж өрсөлдөх чадвараа алдаж байгаа явдал юм. Үүнийг дараах хүснэгтэд байгаа салбаруудын өсөлт тодруулан харуулж байна. Тухайлбал, ТТБ-ын тухай хуулиас болж уул уурхай, эрүүл мэнд, боловсрол, төрийн захиргаа болон батлан хамгаалахаас бусад салбарт илүү өндөр өсөлт гарах хандлагатай байна. Эхний гурван хувилбарт, Засгийн газрын зардал тогтмол хувиар өсөж байгаа учраас, улсын нэрлэсэн хадгаламж зэс, нүүрсний үнийн хэлбэлзэлийг өөртөө шингээж байна. Эдгээр үр дүнгүүдээс үзэхэд ТТБ-ын тухай хууль нь эдийн засгийг тогтворжуулж, салбаруудын тогтвортой өсөлтийг хангаж байна гэж бид үзэж байна.

Нийт гарцын өсөлт (%)	Хувилбар нэг	Хувилбар хоёр	Хувилбар гурав	Хувилбар дөрөв
Мал аж ахуй	3.18	3.05	3.38	2.39
Газар тариалан	0.68	0.58	0.37	0.06
Эрчим хүч	8.50	7.53	9.17	7.85
Аж үйлдвэр	3.87	3.60	9.18	2.79
Тээвэр	24.49	25.02	23.8	24.07
Барилга	18.91	18.96	18.81	19.00
Эрүүл мэнд	4.80	4.39	2.35	8.52
Боловсрол	2.16	1.79	1.76	6.05
Төрийн захиргаа, батлан хамгаалах	4.03	3.64	2.78	10.52
Үйлчилгээ	10.05	9.95	9.49	9.62

Загварын параметруудад илүү боловсронгуй аргаар үнэлэх замаар үр дүнг нарийвчлах боломж байгааг бид ойлгож байгаа. Гэхдээ уг загварыг муу ажиллаж байна гэж бид дүгнэхгүй. Тэнцвэрийн загварын хувьд харин ч сайн ажиллаж байна гэж үзэж байгаа. Учир нь тус загвар 10000 гаруй хувьсагч, 8000 гаруй тэгшитгэлээс бүрддэг. Эдгээрийн 2000 орчим хувьсагчийн бодит утгыг гаднаас эзгөген байдлаар оруулах учиртай. Харамсалтай нь бодит байдал дээр энэ боломж тун бага юм. Үүн дээр нэмээд, загварын гүйцэтгэл ямар байх нь мэдээллийн чанар болон загварын зөв тавилаас хамаардаг. ■


параметруудийн утгыг тодорхойлох илүү боловсронгуй арга хэрэгтэй гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Цаашид бид энэ тал дээр ажиллах болно.

Үүн дээр нэмээд, зэс болон нүүрсний салбарт хүлээгдэж байгаа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөөллийг эзгөген хэлбэрээр оруулж өгсөн.

# АФРИК БОЛ МАНДАЖ БУЙ НАР

Орчуулсан Б.ЦЭЦЭЭ

“The Economist” сэтгүүлийн Африкаас бэлтгэсэн гуравдугаар сарын тусгай дугаарын онцлох нийтлэлийг хүргэж байна.



Дэлхийн хамгийн ядуу тивийн баруун зах буюу Сенегал улсын “Cap-Vert” хойгт /Ногоон нөмрөгт/ орших далайн эргийн нэгэн кафед гурван оюутан “iPad”-аа булаацалдах шахам бөөгнөрөн, бөгтийн суух ажээ. Тэд Европын хамгийн буурай орнуудын нэг Молдавын тухай мэдээллийг цахим хуудаснаас уншиж буй нь энэ. Тэдний шимтэн уншиж буй мэдээллийн нэг нь “Дөрвөн согтуу цэрэг нийлж хүчирхийлэл үйлджээ” гэх мэдээ

байсан бол нөгөө нь Молдав эрчүүдийн хувьд нас барах магадлал архи хэтрүүлэн хэрэглэснээс 19 хувь, тамхитай холбоотой өвчнөөс үүдэн 58 хувь байдаг. Харин үлдсэн хувь нь ямар нэг байдлаар хүний наймаа, хүчирхийллийн хэрэгт холбоотой байдаг тухай өгүүлсэн байв. Грекийн эдийн засгийн доройтлоос эхлээд дээрх төрлийн олон мэдээлэл Африкийн хүчирхэгжиж буй хэвлэл мэдээллийн үндсэн бүрэлдэхүүнд багтах болжээ. Баячуудын ертөнцөд

Африкийн өвчин, өлсгөлөн, эмх замбараагүй байдлын тухай мэдээлэл удаан ноёрхсон шиг эндхийн хэвлэл мэдээллэл ч өрөвдөлтэй ядуу зүүдүү, үл итгэлцлийг түлхүү товойлгон харуулдаг.

Сенегал улсын нийслэл Дакарын захын дүүрэгт гурван оюутан капучино уун, дал модод цуварсан засмал замыг ажин сууна. Энэ бол танан цагаан бүтээлэг бүхий ширээ засаж, ногоон толбот хавчаар зочдоо ▶






алаглуулж мэдэх юм.

Дайн дажин, өлсгөлөн, дарангуйлагч энд нүдний гэм болжээ. Хятад, Энэтхэгийн иргэд шиг энд ч хүмүүс өдөр тутмын хэрэгцээндээ хүрэлцэхүйц мөнгө олох гэж тэмцдэг. Хангалттай идэх хоол, боловсролоор дутаж, өдөр бүр тохиолдох шударга бус байдалд цөхөрч, зарим нь дүрвэхийг ч хүсдэг. Гэвч ихэнх африкчууд өнөөдөр хүчирхийлэл, бага насны хүүхдийн эндэгдэл зэргээс айхаа больж, үр хүүхдүүдийнхээ сайн сайхан амьдрахыг үзнэ гэж мөрөөдөж чадахтайгаа болжээ. Энэ нийтлэлийн төв цэг Сахарын нэг хэсгийг багтаасан тус тивийн дийлэнх хэсэгт уг өөрчлөлт хамаатай.

Африкийн статистик баримт ихэвчлэн итгэхэд бэрх. Гэвч ерөнхийд нь аваад үзвэл, тэдний гаргасан олон янзын тоо Африкт хүний хөгжлийн хувьд огцом үсрэлт гарсан гэдгийг харж болно. Тус тивд орших олон улс сургалтын программаа баяжуулж, сургуулийн төлбөрөө халсны дараах 2000-2008 оны хооронд дунд сургуулийн элсэлт 48 хувиар өсчээ. Өнгөрсөн арав гаруй жилийн хугацаанд хамгийн их өвчинд нэрвэгдсэн улсуудад хумхаа өвчнөөр нас барагсдын тоо 48 хувиар, ХДХВ-ын халдвар авсан тохиолдол 74 хувиар буурсан байгаа юм. Африк тивийн дундаж наслалт өнгөрсөн хугацаанд арван хувиар нэмэгдэж, нөгөө талаас бага насны хүүхдийн эндэгдэл огцом буурсаар байна.

Энэ тивд эдийн засгийн тэсрэлт томоохон өөрчлөлтийг авчирч байна. Сүүлийн арван жилийн хугацаанд нэг хүнд ногдох бодит орлогын хэмжээ 30 хувиар өссөн байна. Түүнээс өмнөх 20 жилд энэ тоо 10 хувиар буурсан байдаг. Одоогийн байдлаар Африк бол дэлхийн хамгийн хурдан өсөлттэй яваа тив. Дараагийн арван жилд дотоодын нийт бүтээгдэхүүн нь жилд дунджаар зургаан хувиар өсөхөөр байгаа нь гадаадын хөрөнгө оруулалтын гавьяа байх аж. 2002 онд 15 тэрбум ам.доллар байсан гадаадын хөрөнгө оруулалт 2006 онд 37 тэрбум ам.доллар болсон бол өнгөрсөн он гэхэд энэ үзүүлэлт 46 тэрбум ам.доллар болтлоо өсчээ. /Хүснэгтийг харна уу/



**Хүснэгт 1**

Ховорт тооцогдож байсан телефон утас тэргүүтэй бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний олдоц хүрэлцэхүйц хэмжээнд хүрчээ. Энэтхэг шиг Африкт дөрвөн хүнд нэг утас ногддог. 2017 он гэхэд нийт айл өрхийн 30 хувь нь зурагттай болох агаад энэ нь арван жилийн хугацаанд 10 дахин өссөн үзүүлэлт болох юм. Нигер улс Америкаас илүү олон коно үйлдвэрлэдэг. Зохиолч, загвар зохион бүтээгч, хөгжимчин, урлагийхан болон кино бүтээгчид итгэл найдварын шинэ салхинд хөөгдөн урагшилж байна. Санал асуулгаар Африкчуудын гуравны хоёр нь энэ жил тэдний хувьд өмнөхөөсөө харьцангуй илүү сайхан жил болно гэж итгэж байгаа бөгөөд энэ нь европчуудын дунд явуулсан санал асуулгатай харьцуулахад хоёр дахин өөдрөг хүлээлт аж.

Нэг бодлого, чиглэлийг дагахад Африк хэт томдоно. Тиймээс улс орнууд хөгжин дэвших өөрсдийн гэсэн арга замаар явж буй. Тухайлбал, Сенегалын гол түлхүүр нь хүчирхэг ардчилал байх жишээтэй. Чийглэг уур амьсгалтай Кап-Вертийн далайн эргээс ялаа шавсан цөлд хүртэл улстөрчид барууныхны жишгээр сонгуулийн кампанит ажил явуулж байна. Ард түмэнд өгөх тэдний үрэлгэн амлалтын зарим нь хэзээ ч биелэгдэхээргүй. Гэвч хамгийн чухал нь тэд ардчилсан институцын эрх үүргийг хүндэлдэг, дагадаг. Өнгөрсөн жил Ерөнхийлөгч асан Абдулай Вад заагдсан хугацааг зөрчин гурав дахь удаагаа сонгогдохыг оролдсон ч түмний дүргүйцлийг хүргэж, шог зургаар хурцхан шүүмжлүүлсэн удаатай. Олонд ихээхэн хүрсэн уг зурагт түүнийг цэнгээний газар гурван аяга кофе захиалж, “Хүн бүрт хоёр аягыг” хэмээх зарлалыг авч

▶ дайлдаг зоогийн газрууд олноороо оршдог хэсэг. Эндхийн зураачид өнгө будаг сүлэлдсэн орчинд хагас нүцгэн тариачин охид зогсож буйг дүрсэлсэн жаазтай зургийг худалдаалж байх ажээ. Энэ бол эрт дээр үед боол ачсан хөлөг шинэ ертөнц рүү аян замд морддог байсан газар. “Тээр цаана амьдардаг хүмүүс энд хэчнээн их зүйл өөрчлөгдсөнийг мэддэг болов уу? хэмээн гурван оюутны нэг тэнгэрийн хаяа дэрлэх нефтийн савыг хуруугаараа давуулан зааж, асуув.

Африкийн тухай барууны дүр зургийг бидний бэлтгэсэн энэхүү тусгай сурвалжлага өөр өнгөөр будан

▶ хаяж буйгаар дүрсэлсэн байдаг. Сөрөг хүчний хэдэн арван нэр дэвшигчид нэгдсэн хүчин байгуулж, түүнд илт ялагдал онооход, тэрбээр үг дуугүй хүлээж авсан билээ. Дакар тэр аяараа ялалтын баяраа нижгэр тэмдэглэсэн ч дараагийн өдрөөс нь даруй ажилдаа орцгоосон юм.

Хүйтэн дайны төгсгөлд Африкийн гуравхан улс / тэр үеийн 53 орноос/ ардчилсан үзэл баримтлалтай байлаа. Түүнээс хойш ардчилсан орон 25 болж өссөн. Олон оронд ардчилал нь төгс бус байгаа ч сонгууль нь үр дүнтэйд тооцогддог. Өнгөрсөн онд л гэхэд тивийн нийт 22 оронд сонгууль болжээ. Нийт 55 орны Эритрэ, Свазилендийн вант улс,

байх зуур Африкийн орнууд иргэдийнхээ амьдралыг дээшлүүлэх гурван өөр замыг сонгожээ.

Нэгдүгээрт, тэд дайтхаа зогсоосон. Сүүлийн үед дайн дажин, иргэний хөдөлгөөн огцом буурсан нь харагдаж буй. Гэсэн ч дотооддоо богино хугацааны зөрчилдөөн дэгдэх нь элбэг байгаа юм. Гэвч өнгөрсөн арван жилийн хугацаанд Африкт дайнд үрэгдэгсдийн тоо харьцангуй буурчээ. Урт удаан хугацаанд гал дүрэлзсэн Ангол, Чад, Эритрэ, Либери, Сьерра Леоны байдал намжиж, сая сая хүний амьдрал дээшилж байна. Мөн Конго, Сомали, Судан зэрэг улсын догшрол харьцангуй намдсан байна. Өнгөрсөн жил Мали улсын зарим хэсгийг

Сенегалд реп урсгалын хэсэг уран бүтээлчид нэгдэн эвсэл байгуулан ноён Вадыг шахан гаргасан билээ.

Гуравдугаарт, Африк социалист эдийн засгийн загвараас ухарсан нь ард иргэдийн амьдрал сайжрахад илт нөлөөлж буй. Этиоп, Руанда зэрэг зарим улс өдийг хүртэл төрөө магнайдаа залсан хэвээр байгаа. Харин Этиопын Ерөнхий сайд агсан Мелес Зенави 1995 оноос эхлэн өнгөрсөн жил нас барах хүртлээ хөгжлийн загварыг гартаа авч, томоохон гавьяа байгуулсан билээ. Бусад Кени, Нигерь зэрэг улс нь хүнд суртлыг арилгаж, хувийн хэвшлийнхэнд арилжааны үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгосон. Африк өөрийн хамгийн том худалдааны түнш болоод буй Хятад улсын эрэлтээс үүдэн таваарын бүтээгдэхүүний тэсрэлтээс асар их ашгийг “амталж” эхлээд байна. Өнгөрсөн арван жилд Африк Хятадын хоорон дахь худалдаа 11 тэрбум ам.доллараас 166 тэрбум ам.доллар болтлоо өсчээ. Зэсээр баян Замби, газрын тосоор “гульгаж” буй Гана шинэ сургууль, эмнэлэг барихад мөнгийг авдар авдраар нь зориулж байгаагийн зэрэгцээ тус улсуудад орж ирж буй их мөнгөний зарим хэсэг нь дундаасаа шамшигдах нь ч бий.

Үгүйсгэж болшгүй үнэн гэвэл, Африкийн сэргэн мандалт эрчимжиж байна. Үүнийг дэмжигчид “Африкийн зууныг” тунхаглаж, “Өчигдрийн Хятад”, “Шинэ Энэтхэг”-ийн тухай ярилцаж сууна. Харин үл итгэгчид Африк үүлэн чөлөөний наранд хууртаж байна хэмээж буй. Тэд гаднын хөрөнгө оруулагчид нутгийнхныг цөлмөж, тив тэр аяараа дээш өргөгдөх бус тонуулаад дуусна хэмээн эмээж байна. Үл итгэгчид мөн ихэнх албан тушаалтнууд авилгалд идэгдсэн агаад шударга улс төрч нь чадвар туршлага дутуун улмаас хэлэлцээрийн ширээнд хөрөнгө оруулагчидтай суухад сул талаа ашиглуулах талтай хэмээн бодож байгаа юм.

Тэгээд хэний зөв юм бэ? Үүнийг олж мэдэхийн тулд л элсэн цөл, бут сөөгөөр баян Дакараас Кэп Таун хүртэл тивийг тэр чигт нь дамнаж, Лагос, Найроби, Йонхансбург зэрэг бүс нутгийн томоохон төвүүдээр ▶



Times Newspapers Ltd

Лив, Сомаль гэсэн дөрвөн улс олон намын тогтолцоогүй засаглалтай бөгөөд сүүлийн хоёр нь тун удахгүй ардчилалд хөл тавихаар зэхэж байна. Цэргийн анги нэгтгэл дийлэнх үед хуарангаасаа гарах хэрэггүй болж. Хэдийгээр захиргаадалтын үеийнхээрээ зарим улс оршсоор байгаа ч нөлөө бүхий удирдагчид ховордсоор байна. Улс төрчид дахин сонгогдохын тулд үр дүн үзүүлэх хэрэг гарч байгаа тул ардчилал тус тивийг нийтэд нь сайн засаглал руу залж байна.

## Аврагдах аргууд

Ардчилал амьдрах гэж тэмцэж

Исламчууд эзэлж, улмаар Францын цэргүүд чөлөөлсөн ч бослого үймээн одоо ч үргэлжилсээр. Төрийн эргэлт, хувьсгалын тоо 1960-1990 оны хооронд нэг арван жилд дунджаар 20 удаа байсан ч арав болтлоо буурчээ.

Хоёрдугаарт, жирийн иргэд илүүтэй улс төр, иргэний нийгмийн бүлэглэлүүд, хүмүүнлэгийн тусламжийн байгууллагад орж ажиллаж болж. Эсэргүүцэгчдийн эгнээг сонгох нь ч байна. Хоёр жилийн өмнө Африкийн хойд хэсэгт дэгдсэн Арабын хавар тивийн бусад хэсэг босч ирэхэд түлхэц болсон гол хүчин зүйл. Анголд залуу идэвхтнүүд холын хойд хэсгийн үйл явдлыг хөхиүлэн дэмжиж буйгаа илэрхийлж байв. Мөн

▶ аялсан билээ. Аяллын хэсэг бүр тус тивтэй салшгүй барьцалдаж буй улс төрийн түрэмгийлэл, засаглал, эдийн засгийн хөгжил хэмээх томоохон сэдэвт гол анхаарлаа хандуулсан болохыг нийтлэлийн үлдсэн хэсэгт илүү тодотгож харуулахыг зорилоо.

Нийт 25400 километр замыг гол мөрөн, төмөр зам, хар замаар туулсан билээ. Биднийн аялсан дийлэнх зам хатуу хучилттай байсан нь бизнес эрхлэх үүд нээлттэй байгааг хэлж байна. Хэдэн жолооч цагдаа нарт гарын мөнгө өгснийг эс тооцбол, аяллын туршид сурвалжлагчид авлигал санал болгосон удаа байгаагүй. Аялал нийт 112 өдөр үргэлжилсний есөн өдөрт нь ухаалаг гар утас ашиглан и-мейл явуулах боломжтой байв. Хүнд, хэцүү аюул заналхийлэл гэдэг зүйл бараг байсангүй. Улсуудын хилийг амархан давж, визийг хэдхэн доллараар газар дээр нь эсвэл нэг өдрийн дотор хамгийн ойрын нийслэлээс авч болдог. Харин 2001 онд Пол Тэрокс “Хар од Сафари: Кайраас Кэп таун хүртэлх хуурай газар” хэмээх адал явдалт аяллын номоо бичихээр ирэхдээ арга буюу албадлаганд автаж тойруу замаар аялж, эцэс төгсгөлгүй бэрхшээлтэй учирч тэр ч байтугай буудуулж, шархадсан удаатай.

Одоогоос арван жилийн өмнө аялагчид Африкийн аль нэг оронд өлсөж үхэх тавилантай учрах магадлал өндөр байдаг байв. Хөдөө аж ахуйн огцом өсөлт, экспортод чиглэсэн аж үйлдвэрлэл, дотоодын үйлдвэрлэлийн эхлэл, жижиглэнгийн худалдааны салбарын өсөлт, илүү нэгдсэн тээвэрлэлтийн үйлчилгээ, илүү шударга сонгууль, илүү бүтээлч Засгийн газрууд, технологийн дэвшилд хүрэх өргөн боломж, өссөөр байх таваарын орлого ядуусын амьдралтай зэрэгцэн бий болж байна. Гэвч тус тивийн бүх улс ийм биш. Энэ сурвалжлага нуран унаж буй олон газрыг хамарна. Гэвч тэдний тоо буурч буй.

## Хүлээ

Итгэж болох шалтгаан нь

өнгөрсөнд хийсэн хөрөнгө оруулалт ашгаа өгч, бодит үр дүн болоход хугацаа шаарддагт оршино. Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд олон тэрбум төгрөгийг аль хэдийнэ зам, сургуульд зарчихсан. Технологийн хувьсгал тивийн хамгийн алслагдмал хэсэгт ч хүрчихээд байна. Мөн шинэ газрын тостой цооног, алтны уул уурхайнуудын үүцийг аль хэдийнэ задалсан ч хараахан бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхлээгүй байгаа. Тусламжаар бүтэж буй дамжуулах хоолой ч бараг бэлэн болчихсон. “Bill and Melinda Gates” сан л гэхэд дангаараа 2006 оноос хойш Африкт 1.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийжээ. Гэвч системээр нь өөрчлөхөд олон жил шаарддагыг энэ бүх үйл явц гэрчилж байна. Зарим хандив тусламж зүгээр л гарз төдий болж, шинэ зарим зам ашиглагдахгүй хаягдаж, цөөнгүй баррель газрын тосоо хулгайд алдаж мэднэ. Дэлхийн банкны тодорхойлолтоор /Нэг хүнд ногдох жилийн орлого доод тал нь 1000 ам.доллар/ дундаж давхаргын ангилалд одоогийн байдлаар Африкийн хүн амын тал хувь ч дөхөж очдоггүй. Дэлхийн банкны зүгээс тус тивийг 2025 он гэхэд дээрх түвшинд хүрнэ гэж хүлээж байна.

Гурав гэсэн дугаарыг гараар зурсан автобус Кап-Вертийн хойгийг орхин Дакар хотын гудамж дундуур аялах зуур шар тос адил үдийн нар Африкийн өнөөгийн гамшиг, ялалтын төрхтэй сүлэлдэх ажээ. Зүүн талаар, хотын ядууст зориулсан цэвэр, бохирын шугаманд холбогдсон түрээсийн байр эгнэнэ. Харин баруун талын толгод дээр 49 метр өндөр хүчирхэг эрийн хүрэл хөшөө сүндэрлэх ажээ. Энэ бол ард түмний 27 сая ам.долларыг үрсэн Сенегалын Ерөнхийлөгч асан Абдулай Вадын залуу үеийг харуулсан хөшөө. Автобус хотыг орхин, хадархаг хавцал, үерэлсэн бэлчээр, урц, мангро моддын ойг өнгөрөн аахилан хурдлах ажээ. Долоон цагийн дараа Зигиншор хотын ойролцоох горхийг гатлан, өмнө зүгийн Гвинея-Бисауруу хүлгийн жолоо залсан юм. ■

## “The Economist” сэтгүүлийн “Pocket World in Figures 2013” гарын авлагаас хүргэж байна

**Pocket World in Figures 2013**  
Хүний хөгжлийн индекс /Хамгийн өндөр/ 2011

1.	Норвеги	94.3
2.	Австрали	92.9
3.	Нидерланд	91.0
4.	АНУ	91.0
5.	Канад	90.8
6.	Ирланд	90.8
7.	ШинэЗеланд	90.8
8.	Герман	90.5
9.	Швед	90.4
10.	Швейцарь	90.3

/Хамгийн доогуур/ 2011

1.	Конго-Киншаса	28.6
2.	Нигерь	29.5
3.	Бурунди	31.6
4.	Мозамбик	32.2
5.	Чад	32.8
6.	Либерн	32.9
7.	БуркинаФасо	33.1
8.	СьерраЛеон	33.6
9.	Төв АБНУ	34.3
10.	Гвинней	34.4

**Эдийн засгийн хараат бус байдлын индекс /2012/**

1.	Хонконг	89.9
2.	Сингапур	87.5
3.	Австрали	83.1
4.	Шинэ Зеланд	82.1
5.	Швейцарь	81.1
6.	Канад	79.9
7.	Чил	78.3
8.	Маврикий	77.0
9.	Ирланд	76.9
10.	Америк	76.3

# ТАРГАН

ОРЧУУЛСАН Б.ЗАЯА

*Таргалалт дэлхий дахинаа цэцэглэж байгаа энэ үед "The Economist" сэтгүүлийн эрүүл мэндийн салбарын сэтгүүлч Шарлот Ховард өөх хэмээх амьгүй булчинтай хэрхэн тэмцэх талаар бичсэн зөвлөгөөг хүргэж байна.*



Урьдчилсан таамаг

\* 20-оос дээш насны

+ Биеийн жингийн индекс нь 25

≠ Биеийн жингийн индекс 30

Эх сурвалж: ДЭМБ

Америкчуудын гуравны хоёр нь илүүдэл жинтэй. Хөгжиж буй улсууд ч таргалалтаар тус улсын араас нэхэж байна. Хятадад насанд хүрэгчдийн 30 орчим хувь нь тарган буюу жингийн илүүдэлтэй байх жишээтэй. Энэ онд дэлхий дахинд бодлого тодорхойлогчид үүний эсрэг ямар нэг зүйл хийх шаардлага зайлшгүй гарна. Гэхдээ яг юу?

Асуудал нь их энгийн. Хүмүүс хоол, хүнснээсээ авсан илчлэгээ гүйцэд шатаах хэмжээний хөдөлгөөн хийдэггүй. Ер нь бол эргээд хэвэндээ орох эсэх нь хувь хүний өөрийн сонголт. Хайрсан боорцог идэх үү, гүйх үү? Гэвч энэ нь таргалалтад нөлөөлдөг хүчин зүйлсийн ээдрээг халхалдаг. Яаж?

Хүмүүс давс, өөх, сахарыг эрхэмлэж, тэдгээрт өлсгөлөнд нэрвэгдэх гэж байгаа аятай л шунан дурладаг болж. Гэтэл хүний бие махбодь ийм төрлийн зүйлд дадаагүй. Түргэн хоол хямд бөгөөд амттай. Компаниуд тэдгээрийг сурталчилахын тулд тэрбум, тэрбум ам.доллар зарцуулдаг. АНУ-ын 1977-2001 оны таргалалтын 20 хувь нь чихэрлэг ундаанаас үүдэлтэй гэсэн тооцоо байдаг аж. 2011 онд 0.33 литртэй "Кока кола"-ны борлуулалт Мексикт дэлхийн бусад орноос илт давуу байжээ. Үр дүн нь тус улсын насанд хүрэгчдийн 30 орчим хувь нь илүүдэл жинтэй гэх тоо.

Түргэн хоол, хийжүүлсэн болон чихэр ихтэй ундаанаас гадна таргалалт руу»

# ДЭЛХИЙ

▶ түлхэж буй өөр нэг хүчин зүйл нь ихэнх ажил биеийн хүчний хөдөлмөр шаардахаа больсон явдал юм. Алхах, дугуйгаар явах хэрэгцээг машин хязгаарлах болов. Мөн гэрийн ойр хавьд тоглоомын талбай ховордсон, гэртээ хоол бэлдэх завгүй эцэг, эхчүүдийн нөлөө ч багагүй. Хүүхдүүд сургууль дээрээ зохистой хоол, хүнс хэрэглэж байгаа эсэх нь бас тодорхойгүй. Хүний биеийн илчлэг ба дасгал хөдөлгөөний тэнцвэр дээрх хүчин зүйлсээс шалтгаалж хазайдаг байх нь.

## Экономистийн дэглэм

Таргалалт нь зүрх, судас, чихрийн шижин, элэг, үе мөчний өвчлөл болон зарим төрлийн хорт хавдар үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Ази хүмүүс барууныхныг бодвол таргалалттай холбоотой өвчлөлд харьцангуй бага жинтэй өртдөг нь тогтоогджээ.

АНУ-ын Анагаах ухааны институтаас Америкт таргалалтаас шалтгаалсан өвчнийг эмчлэхэд жилд 190 гаруй тэрбум ам.доллар буюу эрүүл мэндийн салбарын төсвийн тавны нэг нь зарцуулдаг гэх тооцоо гаргажээ. Таргалалт хөгжиж буй орнуудын эдийн засагт нөлөөлдөг. Биеийнхээ илүүдэл жинтэйгээ эвлэрснээр хөдөлмөрийн бүтээмж буурдаг.

Таргалалтын эсрэг юу хийх вэ, түүнтэй хэрхэн тэмцэх вэ?

Эхний хариулт нь “Юу ч хийхгүй байх”. Хэрэв тухайн хүн тарган бол тарган хэвээр нь орхи. Их Британийн алдарт философич Ноён Стюард Милл “Хэрэв тухайн хүний илүүдэл жин өөрөөс гадна бусдад сөргөөр нөлөөлж эхэлбэл л тусламж,

үйлчилгээ үзүүлж болох юм” гэжээ. Гэвч эмчилгээний төлбөр өндөр бөгөөд чинээлэг орнуудад ихэвчлэн татвар төлөгчдийн мөнгөнөөс суутгадаг аж. Миллийн хариултаар бол таргалалтыг зөнд нь орхих нь зүйтэй аж.

Хоёр дахь хариулт нь “Илүүдэл жинтэй хүмүүсийг шийтгэх”. Японд бэлхүүсний тойрогний хэмжээнд хязгаарлалт тогтоожээ. Хэрэв ажилчид нь жингээ хасахгүй бол, ажил олгогчдыг торгоно. Гэхдээ энэ бол хэтрүүлэг. Гормонд өөрчлөлт ордог тул жингээ хасах, мацаг барих нь тун амаргүй ажил. Тодорхой шалтгааны учраас илүүдэл жинтэй болсон байж болох шүү дээ. Тэдний буруугаас биш ажил, амьдралын нөлөөгөөр эсвэл өвчний улмаас жин нэмсэн байх боломжтой тул энэ хариулт нь хэт өрөөсгөл байгаа юм.

Гурав дахь хариулт нь дээрх хоёр хариултын дундаж гэж хэлж болно. Өөртөө шүүмжлэлтэй хандах боломжийг олгож, өөрөөр нь өөрийг нь өөрчлөх. Сонголтыг хязгаарлах

бус харин хялбаршуулах санаа агуулж байгаа хэрэг. Лууван, шарсан төмс хоёроос эргэлзэхгүйгээр лууванг сонгох бодлыг суулгаж өгөх юм.

Аль нь зөв бодлого вэ? Ирэх жилүүдэд Засгийн газруудад хэрэг болох хэдэн зөвлөгөө дурдья. Ард, иргэдээ брокколи худалдаж авахыг шаардах бус харин тус бүтээгдэхүүний үнийг бууруулахад анхаарах хэрэгтэй. Мөн сургуулийн үдийн хоол эрүүл эсэх, хүүхэд багачуудад гүйж харайх, тоглож наадах цаг, талбай байгаа эсэхэд санаа тавихад илүүдэхгүй. Хоол, тэжээлийн илчлэгт тодорхой стандарт тогтоовол үйлчлүүлэгчид илүү эрүүл хүнс сонгох боломж нээгдэнэ гэсэн үг. Чихэртэй ундаа бол таргалалтын гол жолоодогч тул түүнд ногдуулах татварыг нэмэгдүүлэх шаардлагатай. Хувь хүний эрх чөлөөг дээдлэх эсвэл суудлын даруулгаа зүүнэ үү гэх өдөр болгон чихэнд сонсддог үгстэй цуг хийжүүлсэн ундааны татварын талаарх асуудал яригдаж байх учиртай. ■



WWW.ECONOMIST.COM



Authorized  **TOEIC** Test Provider

## TOEIC ШАЛГАЛТЫГ МЭДЭХ ҮҮ?

**TOEIC шалгалт нь:** Танай байгууллагад англи хэлний мэдлэгтэй, чадварлаг, сайн ажилтныг сонгон шалгаруулж, тогтвор сууршилтай ажиллуулах, ажил, амжилтын гол үндэс болно.

TOEIC нь /Test of English for International Communication/ гэсэн үгний товчлол, бидний мэдэх TOEFL, GRE, SLEP, Praxis зэрэг тестүүдийг зохиосон АНУ-ын ETS /Educational Testing Service/ төвийн шалгалт юм. TOEIC олон улсын шалгалтыг дэлхийн 120 оронд ажилтан сонгон шалгаруулах, албан тушаал дэвшүүлэх, олон улсад ажиллах, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, мэргэжлийн сургалтын түвшинг тогтоох, сургалтын ахицыг дүгнэх зэргээр ашигладаг. Япон, Солонгос, Тайланд, Хятад, Канад Их Британийн Вант гэх мэт улсууд ажлын байрны Англи хэлний мэдлэгийг тодорхойлох үндсэн шалгуур болгон албан ёсоор хэрэглэж байна.

**TOEIC шалгалт нь:** Тухайн байгууллагын ажилтны англи хэлний мэдлэг, чадамжийг хөндлөнгийн нөлөөлөлгүй, үнэн зөв, бодитой тогтоодогт оршино.

## ТА TOEIC ШАЛГАЛТЫГ ӨГСӨН ҮҮ?

Өнөөдөр манай улс дэлхийн хөгжилтэй орнуудын жишигт хүрэхийн тулд Англи хэлтэй боловсон хүчин нэн тэргүүнд тулгамдаж байгаа билээ. Энэ асуудалд цэг тавихын тулд Сантис Боловсролын Төв ажлын байрны Англи хэлний олон улсын TOEIC түвшин тогтоох шалгалтыг Монгол улсад албан ёсны эрхтэйгээр оруулж ирэн төр захиргааны байгууллагууд, томоохон ААН-үүдтэй хамтран ажиллаж байна.

Та TOEIC шалгалтыг өгснөөр тогтвор суурьшилтай ажиллах, өөрийн мэдлэг, чадвараа зөв үнэлүүлэх, албан тушаал ахих төдийгүй дэлхийн хөгжилтэй улс орнуудын нэр, нөлөө бүхий байгууллагуудад өндөрөөр үнэлэгдэн ажиллах боломжтой.

**TOEIC шалгалтын Үндэсний төв: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Оюутны гудамж-16, Сантис Боловсролын Төвийн байр, Утас: 976-11-322794, И-мэйл: toeic@celpa.mn**



### Сургалтын чанар Сантисийн нэр хүнд

- > Ерөнхий англи хэлний 1-7 түвшний сургалт /бүх насныханд зориулсан/
- > Нэг жилийн мэргэжлийн сургалтууд
- > “Эрчимжүүлсэн” болон “Ганцаарчилсан” сургалт
- > Байгууллагын захиалгат сургалт
- > Англи хэлний Онлайн сургалт
- > ЕБС-ийн Элсэлтийн ерөнхий шалгалтын “ЭЕШ Англи -800” бэлтгэл
- > IBT TOEFL, IELTS, TOEIC-ийн шалгалтанд бэлтгэх сургалт
- > IBT TOEFL -ийн олон улсын шалгалт
- > SEPT-ийн Англи хэлний түвшин тогтоох шалгалт
- > TOEIC-ийн ажлын байрны Англи хэлний түвшин тогтоох олон улсын шалгалт

Утас: 318313, 318319

[www.santis.mn](http://www.santis.mn)



### АНУ, Англи, Австрали зэрэг улс орнуудад АЯЛЖ, АНГЛИ ХЭЛ СУРАХ богино хугацааны хөтөлбөр

Бид албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагчдыг АНУ, Англи, Австрали “Inlingua” олон улсын хэлний сургуулийн англи хэл, аялалын богино хугацааны /сурах хугацаа сонголттой/ хөтөлбөрт хамруулж, тухайн орны түүх, соёл, хөгжил цэцэглэлтийг нүдээр харж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцож, хамтран ажиллахыг урьж байна.

“Инлингва Монголиа” Олон улсын хэлний төв  
Утас: 312936  
[marketing@inlingua.mn](mailto:marketing@inlingua.mn)